МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.07.23 № 1640

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн "Прокурорын байгууллагад эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлсэн талаар" 05 дугаартай асуултыг хүлээн авч танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "*Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. ...*" гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас 2020, 2021, 2022, 2023, 2024 оны эхний хагас жилийн байдлаар прокурорын байгууллагад шилжүүлсэн асуудлын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 42 хуудастай.

Д.ЗАГДЖАВ

Z:\awsan_Bichig\2024\0723 XEG-4.doc

0001031251

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024
оны 02 дугаар сарын 23-ны өдрийн
16/Y/D дугаар албан бичгийн хавсралт

ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ БАЙЖ БОЛЗОШГҮЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛСЭН АСУУДАЛ

№	Аудит гүйцэтгэсэн газар	Аудитын он	Аудитын нэр, сэдэв	Зөрчлийн товч утга	Шилжүүлсэн байгууллагын нэр	Хүргүүлсэн албан бичиг	Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэр (мэдээлэл)
	1	2	3	4	5	6	7
1	Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газар	2020	"Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар зээмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх"-д хийсэн нийцлийн аудит	АМГТГ-ын тусгай зөвшөөрөлгүйгээр хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд зөвшөөрөлгүй газар, газрын хэвлий ашиглан уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулсан.	Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс	Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор 2020.01.21-ний өдрийн 07/139	Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан.
2	Үндэсний аудитын газар	2020	"Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн"	ДЦС-4 ТӨХК-ийн хөргөх цамхаг №4 барьсан, ПТ-80-130 маркийн ТГ-6-ийн хүчин чадлыг 20 МВ-аар нэмэгдүүлсэн, ЦДҮС-ийн өмнөд дэд станцын трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн, 2015 онд ДЦС-3 ТӨХК-ийн тарифыг нэмэгдүүлэх замаар Даланзадгад ДЦС-ын 1 дүгээр түрбиныг шинэчилсэн зэрэг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад холбогдох хууль тогтоомж зөрчиж үр ашиггүй зарцуулсан асуудлыг шилжүүлсэн. Эрчим хүчний зохицуулах хорооны даргаар ажиллаж байсан С.Отгонбаяр нь ажлаас чөлөөлөгдсөн тушаал гарсны дараа 216.2 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн.	Авлигатай тэмцэх газар	Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор 2020.03.11-ний 05/765	МУЕПГ-ын 2020.03.20-ны өдрийн 06/3277 дугаар албан бичгээр хөөн хэлэлцэх хугацаа өнгөрч, хэргийг хааж шийдвэрлэсэн тухай хариу ирсэн.
3	Үндэсний аудитын газар	2020	"Эрүүл мэндийн даатгалын Еөрнхий газрын 2019 оны санүүгийн тайланд хийсэн" аудит	1. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 329.0 сая төгрөгийн программ хөгжүүлэх ажлыг иргэн Г.Ариунбаттай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн; 2. ЭМДС-гийн цахим систем программ хангамжийг нэмж хөгжүүлэх хэсэгчилсэн ажлуудыг /5 программын нийт төсөвт өртөг 623.2 сая төгрөг/ төсөвт өртгөөс үл хамааруулж өөр өөр аргачлалаар зохион байгуулсан	Нийслэлийн Прокурорын газар	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор 2020.03.18-ны	МУЕПГ 2020.03.28-ны өдөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тухай мэдэгдсэн.

				зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 24.4, ТБОНӨХБАҮ худалдан авах тухай хуулийн 8.2, 31.1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн; 3.2018 оны 01-06 сарыг дуустал Г.Ариунбат, Г.Мөнхгэрэл, Х.Бат-Оргил нарын 7 иргэн тус бүртэй гэрээ /сарын 3.3 сая төгрөг/ байгуулан нийт 153.8 сая төгрөгийн зардал зарцуулж "Эрүүл мэндийн цахим систем" программ хангамжийг ашиглалтад оруулсан; 4. Уг системийн зохиогчийн эрхийн гэрчилгээг 2018.07.10-ны өдөр Мэдээлэл харилцааны систем ХХК-ны нэр дээр бүтээл туурьвагчаар иргэн Г.Ариунбатыг бүртгүүлж, ТБОНӨХБАҮХАТх-ийн 34.1.2 дахь заалтыг үндэслэн тус компанитай 280.0 сая төгрөгийн төсөвтэй гэрээг шууд байгуулан "Элэг бүтэн монгол хөтөлбөрийн системийг хөгжүүлэх" ажлыг гүйцэтгүүлсэн; 5. "Мэдээлэл харилцааны систем" ХХК-тай байгуулсан гэрээт ажлыг хүлээж авснаас хойш 2018.11.10-ны өдөр "Эрүүл мэндийн цахим систем" программын зохиогчийн эрхийн гэрчилгээг ЭМДЕГ-ын нэр дээр шилжүүлж туурвигчаар Г.Ариунбатыг бүртгүүлсэн; Дээрх байдлаар ЭМДЕГ-ын албан тушаалтнууд 2018 оноос хойш мэдээлэл технологийн хөгжүүлэлтийн зарим ажлыг гүйцэтгүүлэхдээ нээлттэй тендер зарлахаас зайлсхийж, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй асуудлыг шалгуулахаар хүргүүлсэн.		өдрийн 06/904	
4	Үндэсний аудитын газар	2020	"Хөшигийн хөндийн Олон улсын нисэх буудал барих төслийн хэрэгжилт үр дүн"	Автомашины импортын гаалийн бүрдүүлэлтийн баримтад импортлогч Таван Богд ХХК-ийн импортын татвар нэмэгдсэн дүн 147.0 сая төгрөг, уг автомашинд суурилуулсан богино долгионы станцын ижил төстэй загварын зах зээлийн үнэ 1.9 сая төгрөг буюу анхны өртөг нийт 148.9 сая төгрөг байгаагаас үзэхэд "Мицубиши-Чиёода" түншлэлийн нийлүүлсэн үнэ 4.9 дахин их буюу зах зээлийн үнээс хэт өндөр үнэлсэн. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дээрх тогтоолд гал унтраах, авран хамгаалах ангийн штаб командын машин, эмнэлгийн машиныг тус тус давхардуулан тусгасан, JTMHVO5J504205795 арлын дугаар бүхий тус автомашиныг нь 1,003,787,000.0 төгрөгийн балансын үнэтэй тусгасан нь тус тогтоолыг хянаж баталгаажуулсан албан тушаалтнууд албан үүрэгтээ хайнга хандсан байж болзошгүй.	Нийслэлийн Прокурорын газар	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч 2020.04.06-ны өдрийн 01/1080	МУЕПГ-ын 2020.06.04-ний өдрийн 1/1655 дугаар албан бичгээр Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн талаар хариу ирсэн. (2020 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 147 тогтоол)
5	Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	2021	"Хүнс, хөдөө аж ахуйн газраар дэмжин хэрэгжиж буй төсөл,	Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар үлийн цагаан оготнотой тэмцэх зориулалтаар хуваарилагдсан хөрөнгөөс зориулалтын бусаар зарцуулсан.	Улсын Ерөнхий Прокурорын газар	Монгол Улсын Ерөнхий аудитор	МУЕПГ-ын 2021.09.15 4/2036 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт

			хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"			2021.09.09 2011	шилүүлсэн тухай хариу ирсэн.
6	Ховд аймаг дахь Төрийн аудитын газар	2021	"Зэрэг сумын сургуулийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	Хүүхдийн хоолны хэмнэгдсэн, төсөвт төвлөрүүлэх зардлаас тус сургуулийн захирал Н.Галаагийн хүү Г.Өөдэй нэг удаагийн тэтгэмж авахаар хуурамч баримт бичиг бүрдүүлсэн.	Улсын Ерөнхий Прокурорын газар	Монгол Улсын Ерөнхий аудитор 2021.06.29-ний өдрийн 1684	МУЕПГ-ын 2021.07.84 4/1574 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилүүлсэн тухай хариу ирсэн.
7	Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар	2021	"Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	ББУТ констракшн ХХК-ийг ажлын явцад хяналт хийгээгүй байхад гэрээний үнэ 11.663.743 төгрөгийн санхүүжилтийг олгосон.	Улсын Ерөнхий Прокурорын газар	Монгол Улсын Ерөнхий аудитор 2021.06.29-ний өдрийн 725	МУЕПГ-ын 2022.03.09-ний өдрийн 38 дугаар тогтоолоор хэрэгсэхгүй болгосон.
8	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Орон нутгийн 2022 оны төсвийн орлого нэмэгдүүлэх зарлагыг бууруулах санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт өгөх" аудит	Засаг даргын 17 захирамж, ЗДТГ-ын даргын 16 тушаалаар гаргасан нийт 98,986.5 мянган төгрөгийн зарцуулалт нь санхүүгийн баримтаар нотлогдохгүй байсан.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.01.20 131	МУЕПГ-ын 2022.01.28 4/864 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар НПГ-т шилжүүлсэн талаар хариу ирсэн.
9	Ховд аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"	Зураг төсөв хийх санхүүжилт аваад хугацаандаа зураг төсөөе хүлээлгэн өгөөгүй, гэрээнд заасан ажлаа хийгээгүй, гэрээний тусгай нөхцөлд заасан алданги тооцоогүй.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.01.31 168	МУЕПГ-ын 2022.02.15 4/1079 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилүүлсэн тухай хариу ирсэн.
10	Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"	1. Завхан аймгийн "Хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтцийн төсөл"-ийн 6 дугаар багц ажил болох Идэр сумаас Ногоон нуур хүртэлх 22 км авто зам засах, гүүр барих ажлын гүйцэтгэгч Төгс зам ХХК нь тус замын трасс, гүүрийн байршлыг дур мэдэн өөрчилж, херсний инженер, геологийн дүгнэлтийг үндэслэхгүйгээр гүйцэтгэсэн бөгөөд энэ ажил нь байршлын хувьд Хар нуураас хол хамааралгүй, авто замын засвар, шинэчлэлийн ажлын батлагдсан зураг төсөлгүй; 2. Завхан аймгийн Идэр сумын Идэрийн гол дээгүүр 36 У/М модон гүүрийг барих ажлыг Тэргүүн марал зам ХХК 100 сая төгрөгийн төсөвт өртгөөр, Төгс зам ХХК 120 сая төгрөгөөр гүйцэтгэхээр тус тус санал ирүүлсэн боловч Төгс зам ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулсан шалтгаан	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.01.11 90	1. МУЕПГ-ын 2022.02.15 4/1079 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн. 2. МУЕП-ын 2023.07.04 1/6015 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				нь тодорхой бус; 3. Зам засварын ажлын төсөвт өртгийг тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Батцэнгэл 200.0 сая төгрөгөөр баталсан боловч ажил гүйцэтгэх гэрээг Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан гүйцэтгэгч талтай 300.0 сая төгрөгөөр байгуулсан; 4. Барилга угсралт, их засварын ажлын явцын гүйцэтгэлийг ижил цаг хугацаанд 200.0 сая, 300.0 сая төгрөг гэж зөрүүтэй гаргасан байхад захиалагчийг төлөөлж холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулан, Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан баталж, 300 сая төгрөгийн санхүүжилт олгосон.			
11	Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Хүнсний аюулгүй байдлыг хангах өнөөгийн тогтолцоо, төсвийн зарцуулсан хөрөнгийн үр дүн"	Завхан аймгийн Улиастай сумын иргэн, малын их эмч Р.Цагаанбаатар тус сумын мал эмнэлгийг 1999 онд хувьчлан авч 2000 оноос хойш ажиллуулж байгаад 2020 онд Манлай баян ургац ХХК-д /мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж, эм урвалж, гарын авлага, тавилга, эд хөрөнгө/ 18.0 сая төгрөгөөр худалдсан байна. Тус компани "Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангаас 8.0 сая төгрөгийн дэмжлэг авч дээрх мал эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдсан. Аудитын явцад 8.0 сая төгрөгийг Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангаас зээлж авсан нь албан тушаалын байдлаа урвуулан ашигласан байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.02.17 216	МУЕПГ-ын 2022.03.17 4/1751 дугаар албан бичгээр харьяаллын дагуу Завхан аймаг дахь Прокурорын газарт шилжүүлсэн талаар хариу ирсэн.
12	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүн"	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого хэрэгжилт үр дүн аудитын явцад 2018-2021 оны нийтийг хамарсан ажилд горим сорил хэрэгжүүлэх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудал илэрсэн байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.05.25 1139	МУЕПГ-ын 2022.06.08 4/3747 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
13	Нийслэл дэх аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Налайх дүүргийн Халамжийн сан" болон "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК-ийн 2021 оны санхүүгийн аудитын тайланд хийсэн"	"Налайх дүүргийн Халамжийн сан" болон "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 40,614.2 мянган төгрөгийн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудал илэрсэн байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.05.25 1147	МУЕПГ-ын 2022.06.09 4/3769 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

14	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"	2019 онд Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн ажиллагсдын хувийн орон сууцыг дулаанаар хангах зорилгоор 425 метр дулааны шугамыг "Грийн радианс" ХХК өөрийн хувийн хөрөнгөөр хийж ашиглалтад оруулсан байдаг бөгөөд уг дулааны шугамаас төрийн зарим байгууллагууд дулаанаар хангагдах нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор дулааны шугамыг төрийн мэдэлд авах зорилгоор Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд "Цагдаагийн хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн гадна шугам сүлжээ худалдан авах ажил" нэрээр оруулан батлуулж, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Уг дулааны шугамыг худалдан авах ажил нь 2 жилийн өмнө хийгдсэн ажил учраас тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй гэсэн шалтгаанаар "Грийн радианс" ХХК-тай шууд гэрээ байгуулсан. 1.Тус компани нь тендерийн баримт бичгийн Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 18.1.г-д (Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл сүүлийн 2 жил 2019, 2020), 18.2.а-д (Сүүлийн 2 жил /2019, 2020 он/ жилийн борлуулалтын орлого нь жил тус бүр санал болгож буй үнийн дүнтэй дүйцэхүйц байна), 18.2-т (Ашигтай ажилласан байх жилийн тоо/ сүүлийн 2 жил/ 2019, 2020 он) гэсэн шалгуурыг хангаагүй тул тендерт оролцоогүй гэдгээ нотолсон албан бичиг ирүүлсэн байхад захиалагч шууд гэрээ байгуулсан; 2."Грийн радианс" ХХК нь захиалагчтай шууд гэрээ байгуулсан боловч тухайн дулааны шугамыг хэдэн төгрөгөөр худалдах үнийн санал болон тооцоог ирүүлээгүй, шугамыг 2 жил ашигласан байтал тухайн худалдан борлуулах үеийн бодит үнэлгээг хийлгээгүй (элэгдэл, хорогдол тооцоогүй), гэрээнд нэмэлтээр тусгасан боловч ажлын гүйцэтгэл байхгүй, ажлыг хүлээн авсан актад нэмэлт ажлын талаар огт дурдаагүй, хүлээн аваагүй; 3.Шууд гэрээгээр худалдан авсан гэх 320.0 сая төгрөгийн өртөг бүхий шугамыг аймгийн Цагдаагийн хэлтсийн данс бүртгэлд тусгуулсан. Энэ нь орон нутгийн төсвөөр бэлтгэсэн, нийтийн эзэмшлийн, дэд бүтцийн ач холбогдол бүхий хөрөнгийг улсын төсвийн байгууллагын дансанд бүртгүүлсэн, бүртгэсэн шугамын тоо хэмжээ зөрүүтэй, цаашид шугамын ашиглалтын зардал, засвар үйлчилгээг аймгийн Цагдаагийн хэлтэс хариуцахаар тусгасан; 4."Грийн радианс" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн дулааны шугамын ажил магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвгүй, дулааны шугамыг ашиглалтад хүлээн авсан	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.07.01 1313	МУЕПГ-ын 2022.07.21 4/4599 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				улсын комиссын актгүй, захиалагч хяналтын төсвийг бэлтгэн магадлалаар баталгаажуулаагүй, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоос хүлээн авсан ажлын тоо хэмжээ зөрүүтэй зэрэг зөрчил илэрсэн байна.			
15	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг"	Аудитаар Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн үүсч хөгжсөний 50 жилийн ойг тэмдэглэхдээ 135.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авах ажлыг тендер буюу сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулсан нь Төрийн өмчийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч 2022.11.10 01/1808	МУЕПГ-ын 2022.11.17 4/7502 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
16	Үндэсний аудитын газар	2022	"Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2021 оны санхүүгийн тайлангийн тєсвийн гүйцэтгэл"	1. 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 462,000,000 төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан; 2. "Re_Package 7. MN-MOH-180322-GO-RFQ-Мэдрэлийн сэхээн амьдруулах төхөөрөмж" тендерийн "Багц 2. Neurological an EEG equipment" ажлын төсөвт өртөг 98,592,008 төгрөг байсныг 167,820,000 төгрөгөөр, "Re_Package 5. MN-MOH-201880-GO-RFQ-ЭЭГ, Холтер Монитор" тендерийн төсөвт өртөг 64,125,000 төгрөг байсныг 97,210,000 төгрөгөөр буюу нийт худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан дүнгээс 102,312,992 төгрөгөөр хэтрүүлэн "Сүвэн-Уул" ХХК-тай гэрээ байгуулсан. Эрүүл мэндийн яамны харьяа "Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл"-ийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй буюу 10,000 хуруувы пульсоксиметр нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, тендерт нийт 3 компани материал ирүүлснээс "Мед импекс интернэшнл" ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулсан байна. Үнэлгээний хорооны 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлээс үзвэл "Сүвэн-Уул" ХХК-ийн ирүүлсэн үнийн санал нь төсөвт өртгөөс 70,2 хувиар буюу 69,207,992 төгрөгөөр давсан, мөн ерөнхий шаардлагыг бүрэн хангаагүй байхад "ирүүлсэн тендер нь ерөнхий шаардлага болон техникийн үзүүлэлтийг хангаж байгаа тул тендерийн үнээ батлагдсан төсөвт өртөг хэтэрсэн ч гэрээ байгуулах эрх олгохоор" шийдвэрлэсэн байна. Үнэлгээний хорооны 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлээс үзвэл "Сүвэн-Уул" ХХК-ийн ирүүлсэн үнийн санал нь төсөвт өртгөөс 33,085,000 төгрөгөөр давсан байхад "тендерийн үнэ батлагдсан төсөвт өртөгтөө багтаж байгаа тул гэрээ байгуулах эрх олгохоор" шийдвэрлэж, төсөвт өртөгт багтсан буюу	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022.04.12 874	МУЕПГ-ын 2022.04.26 42686 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар АТГ-т шалгуулахаар НПГ-т шилжүүлсэн талаар хариу ирсэн.

				39,600,000 төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Нуган" ХХК-ийг шалгаруулаагүй байна.			
17	Үндэсний аудитын газар	2022	"Улсын төсөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам барих төслийн хэрэгжилт"	1. Шинжээчийн багийн ахлагч Д.Энхтуяа нь Зам, тээврийн хөгжлийн яаманд ажиллаж байгаад 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдөр өндөр насны тэтгэвэрт гарсан байх бөгөөд тус яаманд ажиллаж байх хугацаандаа "Баянхонгор аймгийн Байдрагийн гүүрнээс Харганы худаг чиглэлийн 85 км", "Харганы худгаас Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын төв орчим чиглэл"-ийн 92 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн "Техникийн даалгавар"-ыг боловсруулж, "Зураг төсөл боловсруулах гэрээ"-г байгуулахад захиалагч талыг төлөөлөн оролцож, зураг төсөл боловсруулах ажлын явцад хяналт тавьж, актаар хүлээлцэн авч ажилласан талаар аудитын тайлагналын үе шатны явцад архивын баримтууд гарч ирсэн байна. 2.Шинжээчийн багийн ахлагч Д.Энхтуяа Зам, тээврийн хөгжлийн яаманд ахлах мэргэжилтэн, шинжээч зураг төсөл, үнэ бүрдэл, нормативын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байхдаа Үндэсний аудитын газарт шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх, барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн "Дархан-Сэлэнгийн бүсэд уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн "Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн 95 км хатуу хучилттай авто зам барих төсөл"-ийн зураг төсөл, хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлэх шинжээчээр шалгарч, дүгнэлт гаргасан байна. Эдгээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулахын өмнө шинжээчийн багийн ахлагч Д.Энхтуяа нь Үндэсний аудитын газарт гаргаж өгсөн "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-д "ашиг сонирхлын зөрчилгүй" гэсэн байдаг. Гэтэл шинжээчээр ажилласан Д.Энхтуяа нь Зам, тээврийн хөгжлийн яаманд ахлах мэргэжилтэн, шинжээч зураг төсөл, үнэ бүрдэл, нормативын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байхдаа ашиг сонирхлын зөрчлийг үнэн зөв мэдүүлэх үүргээ биелүүлээгүй байна. Шинжээчийн багийн ахлагч Д.Энхтуяа нь худал мэдүүлэг гарган, орлого олох зорилгоор Үндэсний аудитын газрын шинжээч сонгон шалгаруулах ажиллагаанд оролцсон ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон гэж үзэхээр байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.04.18 898	МУЕП-ын 2022.05.09 4/3051 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

18	Үндэсний аудитын газар	2022	"Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"	1.Эрүүл мэндийн сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутагт орших Геронтологийн төв, ахмадын 60 ортой эмнэлгийн барилга нь тэнхлэгээрээ 15.6х27.6 м зоорьтой 5 давхар цутгамал төмөр бетон хийцтэй барилга (Г, Б блок), 27.6мх15.6м, 15.6мх15.6м (В блок) хэмжээтэй зоорьтой 6 давхар цутгамал төмөр бетон хийцтэй. Эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх БУ-12/11 дугаар 2,995,162,425.00 төгрөгийн дүнтэй гэрээг "Арвис интернэшнл" ХХК-тай 2011.10. 28-ны өдөр Эрүүл мэндийн яам байгуулсан. Уг гэрээнд талууд 2017.12.14, 2018.12.10, 2020.10.06-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч гүйцэтгэлийн чанар байдлаас болон улсын төсөвт санхүүжилтэд хөрөнгө батлагдаагүй шалтгаанаар барилгын ажил бүрэн зогссон байна. Гэрээнд 2017 онд орсон өөрчлөлтөөр үнийн дүнг 7,392,867,000.00 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Барилгын ажлын бодит гүйцэтгэлийг зураг төсөл, төсөвт баталсан ажлын тоо хэмжээгээр тооцоход 3,648,188,914.00 төгрөг буюу 48.0 хувьтай байхад 6,214,575,414.00 төгрөгөөр санхүүжүүлсэн нь гүйцэтгэгчид 2,566,386,500.00 төгрөгийг илүү олгосон. Мөн холбогдох албан тушаалтан гэрээнд удаа дараалан нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосон гэмт хэргийн шинжтэй байна. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад баталсан хуулийн XIII.1.1.129 дугаар Цэцэрлэгийн барилга буулгаж, барих, 360 ор (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 39 дүгээр цэцэрлэг) төсөл, арга хэмжээний тендерийг 2019 оны 10 сард 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр зарлаж, барилга угсралтын ажил гүйцэтгэх ТӨБЗГ-2019/XII.1.1.293 дугаар анхны гэрээг 1,598.9 сая төгрөгийн дүнтэй 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Баярс констракшн ХХК-тай байгуулсан байна. Төсөвт ертгийг 2020.10.26-ны өдрийн 2009/2020 дугаар МЕД-ээр 3,896.6 сая төгрөгөөр баталгаажуулсныг үндэслэн 2021.07.01-ний өдөр ТӨБЗГ-209/XII.1.1.293+2 дугаар нэмэлт санхүүжилтийн гэрээг 3,896.6 сая төгрөгийн дүнтэй байгуулсан боловч тендерийн хэмнэлт 401,048,847.00 төгрөгийг хасаж тооцоогүй нь Төрийн	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.06.29 1297	МУЕПГ-ын 2022.07.21 4/4610 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

				болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т "нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасныг зөрчсөн. 3. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан хуулийн XIII.1.1.193 дугаар Цэцэрлэгийн барилга, 280 ор (Баянхонгор, Баянхонгор сум) барилга угсралтын ажлыг гүйцэтгэх БСШУСЯ/201801144 дугаар гэрээг Гал хонгор ХХК-тай 2018.06.25-ны өдөр байгуулж, ашиглалтад оруулах 15 хүний бүрэлдэхүүнтэй комиссын 2019.08.22-ны өдрийн дүгнэлтээр барилгыг байнгын ашиглалтад оруулсан байна. Гүйцэтгэлээр авсан санхүүжилтээс хийгдээгүй ажилд 107,085,372.00, гадна цахилгаан хангамжийн ажлын тоо хэмжээний зөрүүнээс хасаж тооцох 100,000,000.00, зарим ажлыг давхардуулж гүйцэтгэл бичсэн 312,987,857.00, нийт 520,073,229.00 төгрөгийг илүү олгосон. 4. Монгол Улсын Ерөнхий сайдын багцад Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан хуулийн III.1.1.14 дугаар Усан бассейн, спорт фитнесийн барилга (Увс, Улаангом сум) угсралтын ажлыг гүйцэтгэх БСШУСЯ/201902370 дугаар 4,090,462,292.00 төгрөгийн дүнтэй гэрээг Зунбоо ХХК-тай 2019.09.07-ны өдөр байгуулж, үе шатны ажлын гүйцэтгэлийг 2019.11.22-ны өдрийн №01, 2020.12.03-ны өдрийн №02 дугаар гүйцэтгэлээр баталгаажуулан гүйцэтгэгчид 2,377,379,809.0 төгрөгийн санхүүжилт олгосон байна. Объект дээр хийсэн хэмжилт, экспертиззэр баталгаажсан төсөв, тендерийн төсвийг бодит гүйцэтгэлтэй харьцуулахад Зунбоо ХХК-д 244,159,546.00 төгрөгийн гүйцэтгэлийг илүү бичиж олгосон, мөн ажлын гүйцэтгэл №01-ээр бассейны тоног төхөөрөмжийн гэрээний урьдчилгаанд олгосон боловч уг тоног төхөөрөмжийг нийлүүлснийг нотлох баримтгүй 700,000,000.00 төгрөг, нийт 944,159,546.00 төгрөгийг олгосон. 5. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан хуулийн XIII.1.1.131 дугаар Цэцэрлэгийн барилга худалдан авах /Ховд, Жаргалант сум, Жаргалан			

12

				баг/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах БСШУСЯ/202001289 дугаар 329,900,000.00 төгрөгийн Арвис сакура ХХК-тай 2020.09.02-ны Ховд аймгийн Засаг даргын орлогчтой байгуулсан байна. Уг гэрээний хэрэгжилтийн үр дүн нь төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томьёотой тохироогүй, тендерийн жишиг баримт заагдсан тодорхойлолт шаардлагад нийцээгүй, худалдан авах барилгад үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр үнэлгээ хийлгээгүй, барилгын чанар, стандарт нь ашиглалтын шаардлага хангаагүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргаагүй, комиссын зарим гишүүд хүлээн авах боломжгүй тухай санал гаргасан байхад хүлээн авсан. Мөн Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгийн барилгыг шинээр барих болж, хуучин барилгыг буулгасантай холбоотой цаашид ашиглах боломжтой болон боломжгүй болсон эд хөрөнгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдсаны орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, Орон нутгийн өмчийн газар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байх эрсдэлтэй байна.			

19	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	2022	"Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас үндсэн үйл ажиллагааны нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 0.8 сая төгрөг зарцуулсан; 2. ИТХ-ын 2021 оны хуралдааны зардлаас УИХ-ын гишүүд, сэтгүүлчдийн хоол, зочид буудлын зардалд 0.5 сая төгрөг зарцуулсан; 3. Бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардлаас дотоодын зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 0.5 сая төгрөг, хуралдааны зардалд 0.2 сая төгрөг зэрэг нийт 0.7 сая төгрөг зориулалтын бусаар зарцуулсан; 4. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд 0.4 сая төгрөг зарцуулсан; 5. Баяр наадын арга хэмжээний (Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн аяга, бал, дэвтэр гэх мэт бэлэг дурсгалын зүйл) зардалд зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 7.6 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 3.4 сая төгрөг зэрэг нийт 11.0 сая төгрөг зориулалтын бусаар зарцуулсан; 6. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал болон хуралдааны зардлаас бусдад бэлэг өгөх гэх үндэслэлээр 0.5 сая төгрөгийн архи, 0.5 сая төгрөгийн чихэр зэргийн худалдан авсан зэрэг зөрчил илэрсэн.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2022.07.01 1312	Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 232 дугаар тогтоолоор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан.
20	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Халамжийн сангийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө"	Бүлгийн төсөлд хамрагдсан иргэдээс түүвэрлэн шалгахад төслийн талаар мэдээлэл байхгүй, төсөлд хамрагдсан эсэхээ мэдэхгүй, мөнгө аваагүй гэх иргэд байна. Төсөлд хамрагдаагүй иргэдэд мөнгө олгосон байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.01.02 04	МУЕПГ-ын 2023.01.11-ний 4/536 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
21	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг"	Дарив сумын Эрчим хүч ААТҮГазар нь 2018-2021 онд нийт 83.0 сая төгрөгийн зээлийн гэрээ байхгүй, байгууллагын дансаар дамжуулаагүй анхан шатны баримтгүйгээр хувь хүний данс руу шилжүүлсэн.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.01.03 08	МУЕПГ-ын 2023.01.11-ний 4/536 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

22	Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Эрдэнэ-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	Эрдэнэ-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн санхүүгийн тайланд Орхон аймгийн Бөхөнгийн зуслан гэх газарт байрлах 10 ширхэг нийт 125,000,000,00 төгрөгийн анхан өртөгтэй зуслангийн байшин бүртгэлтэй байдаг. Тус зуслангийн байшин нь тухай компанийн ажилтнууд амрах зориулалттай бөгөөд хажуугийн нь амралтын газар үйл ажиллагаа явуулдаг цэвэр ағаартай модон дунд байгалийн газар байрладаг. Эрдэнэ-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК 10 зуслангийн байшинг зөвшөөрөлгүйгээр амралтын газрын зориулалтаар ашиглаж нэг өдрийн 70.0 төгрөгөөр тооцож амрагч хүлээн авч орлого олж байгаа нь тогтоогдсон.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.01.03 09	1МУЕПГ-ын 2023.01.11-ний 4/536 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн. 2.МУЕПГ-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 1/6015 дугаар албан бичгээр 231500107 хэрэг нээж шалгаж 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хэрэгсэхгүй болсон.
23	Булган аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Аймгийн төсвийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүн"	Аймгийн ИТХ-ын "2021 онд ойгоос мод бэлтгэх модны хэмжээнд өөрчлөлт оруулах тухай" 2021.07.26-ны өдрийн IV/06 дугаар хуралдааны тогтоол, Орхон сумын ИТХ-ын "Ойгоос бэлтгэх модны хуваарийг батлах тухай" 2020.12.18-ны өдрийн II/07 дугаар хуралдааны тогтоолоор цэвэрлэгээний ажлаас гарах түлээ 10,000 метр,куб, цэвэрлэгээнээс гарах хэрэглээ 700 метр.куб-ээр тус тус баталсан байна. Булган сумын дундын ойн ангиар 244.5 га талбайд цэвэрлэгээнээс гарах нийт хэрэглээг 499.3 метр.куб, түлээг 6220 метр куб-ийг олгохоор талбай тусгаарлалтын гэрээ байгуулсан. Гүйцэтгэлээр Орхон сумын байгаль хамгаалагч нар цэвэрлэгээнээс гарах хэрэглээний модыг 4547.75 метр.куб-ээр, цэвэрлэгээнээс гарах түлээний модыг 7175.69 метр.куб-ийг олгосон байна. Аудитаар Орхон сумын ИТХ-ын 2020 оны II/07 дугаар хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг 3495.75 метр.куб-ээр, талбай тусгаарлалтын гэрээнд заасан хэмжээг цэвэрлэгээнээс гарах хэрэглээний модыг 4048.45 метр.куб-ээр тус тус хэтрүүлэн мод бэлтгэх эрхийг олгосон нь Ойн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.1. "гэрээ, зөвшөөрлийн баримт бичиг заасан тоо хэмжээ хэтрүүлсэн, төрөл зориулалт, бэлтгэх арга, технологийг зөрчиж мод бэлтгэсэн"-д заасан мод бэлтгэх ажиллагааг зөрчсөн.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.01.03 16	МУЕПГ-ын 2023.01.13-ны 4/618 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
24	Төв аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, нөхөн сэргээлт"	Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга Л.Төмөрчөдөр Ган-Майнинг ХХК-ийн захирал Д.Ганбаатараас нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан 150.0 сая төгрөг өгөхийг шаардаж, тухайн мөнгийг өгөөгүй тул компанийн байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх үүргийн хэрэгжилтийн талаарх албан бичиг өгөхөөс татгалзсан байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.01.26 140	Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 4/1531 дугаартай албан бичгээр Эрүүгийн хэрэг хянан

							шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлд заасны дагуу шалгаж шийдвэрлүүлэхээр Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн талаар хариу ирсэн. (Төв аймгийн Прокурорын газрын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 166 дугаартай Прокурорын тогтоол)-оор "Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай" прокурорын тогтоол гарч хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн.
25	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дансанд бүртгэлтэй Ланд 200 маркийн автомашинд төсвөөс 25,765.4 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан боловч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.12.27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор эзэмшигчид нь 1,000.0 төгрөгөөр; 2. Аймгийн Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 2020 онд 11,520.0 мянган төгрөгөөр худалдан авсан Сонато-7 загварын автомашиныг 8,640.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй байхад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.12.27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор эзэмшигч нь 1,500.0 төгрөгөөр; 3. Аймгийн Засаг даргын Тамгын газарт хөрөнгөд бүртгэлтэй байсан Ниссан X-trail загварын автомашиныг Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.11.30-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор шилжүүлсэн боловч 202.12.27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор эзэмшигчид нь 1,000.0 мянган төгрөгөөр; 4. Тус аймгийн Жаргалант сумын ИТХ-ын ажлын албанд бүртгэлтэй элэгдлээ бүрэн нөхөөгүй үлдэх өртөгтэй 2018 онд үйлдвэрлэсэн УАЗ-31519 загварын автомашиныг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 202.12.27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор 300,0 төгрөгөөр; 5. Есөнбулаг сумын ИТХ-ын ажлын албанд бүртгэлтэй Ланд-80 маркийн автомашиныг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч 2023.01.26 01/152	МУЕПГ-ын газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 4/1531 дугаартай албн бичгээр ЭХХШТ хуулийн 30.7 заасны дагуу Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн талаар хариу ирсэн.

16

				тогтоолоор 500,0 төгрөгөөр; 6. Алтай сумын Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 2017 онд үйлдвэрлэсэн УАЗ-Хантер маркийн автомашиныг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.15-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор 2,500.0 төгрөгөөр тус тус худалдсан болох нь холбогдох баримтуудаар нотлогдож байна.			
26	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Увс аймгийн Засаг дарга, Тамгын даргын 2021, 2022 онд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт үр дүн"	Аймгийн Засаг даргын 17 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 16 тушаалаар нийт 98,986,5 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гарч хоол болон жимс, бэлэг худалдан авсан хэдий ч тухай материалыг хэдэн хүнийг хүлээн авахад хооллоход зарцуулсан нь нотлогдоогүй.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.02.09 186	Нийслэлийн прокурорын газрын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 209 дугаартай "Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай" Прокурорын тогтоолоор хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.
27	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, тесвийн гүйцэтгэлд хийсэн" аудит	Прокурорын газарт нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Анхзаяа нь албаны эрх мэдлээ ашиглаж нэмж олгосон цалин нэрээр 3.9 сая төгрөгийг хувийн данс руугаа шилжүүлэн авч хуурамч баримт бүрдүүлсэн, туслах ажилтнаар ажиллаж байсан П.Насанбатад давуу байдал үүсгэж 1.8 сая төгрөг илүү олгосон байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.03.20 604	МУЕПГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 4/3258 дугаартай албан бичгээр Увс аймаг дахь Цагдаагийн газраас хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байгаа эрүүгийн 233500029 дугаартай хэрэгт нэгтгэн шалгуулах хэрэгт хяналт тавьж буй Ховд аймгийн прокурорын газарт шилжүүлсэн талаар хариу ирсэн.

17

28	Үндэсний аудитын газар	2023	"Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн" аудит	1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Баярсайханд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүдийн хуралд баримтлах удирдамжийг 2020.02.17-ны өдрийн 01/463 дугаар албан бичгээр хүргүүлжээ. Тус удирдамжийн 2-т "Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашгийг иргэд, хуулийн этгээдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлэх" гэж заасныг үндэслэн тус компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гарсан байна. ТУЗ-ийн 2020.02.17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор "...төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ашгийг компанийн эзэмшиж байгаа үнэт цаасаар хуваарилах"-аар шийдвэрлэж, ТУЗ-ийн 2020 оны 20 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох 880.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан хаалттай өрийн бичиг, Тавантолгой түлш ХХК-аас авах авлагаар төлж хуваарилахаар шийдвэрлэж, дээрх шийдвэрийн дагуу ногдол ашгийг үнэт цаас, мөнгөн хэлбэрээр олгохоор шийдвэр баталгаажсан байна. 2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээний хавсралт "В" болох Эрдэнэс-Тавантолгой ХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан нүүрс нийлүүлэх гэрээний (ЭТТ-2019/784/BI-TTGS-CONT-0003 дугаартай) 3.2-т "Худалдагч нь энэхүү гэрээний 3.1-д заасан санхүүжилтийг мөн гэрээгээр тохирсон нөхцөл шаардлагын дагуу Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчдад Гэрээт талбайгаас олборлосон нүүрс нийлүүлэх замаар нөхөн төлж барагдуулах бөгөөд Талууд нүүрс худалдах, худалдан авах гэрээг тусдаа байгуулна" гэж заасныг үндэслэн Бодь интернэшнл ХХК-д төлөх төлбөрийг түүний сонгосон нэрлэсэн худалдан авагчтай нүүрс борлуулах гуравласан гэрээ байгуулж, нүүрсээр төлж байна. Энэ нь гэрээг бусдад шилжүүлсэн гэх агуулга биш, харин уг гэрээний 7.1 дэх хэсэгт зааснаар гүйцэтгэгч буюу Бодь интернэшнл ХХК нэрлэсэн худалдан авагчийг шууд сонгон, нүүрс худалдах, худалдан авах гуравласан гэрээ байгуулах боломжийг олгосон байна. 3. АМГТГ-аас 2006 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-д ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн талбайд 68471.43 га	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.05.05 990	МУЕПГ-ын 2023.05.22-ны өдрийн 4/4625 дугаартай албан бичгээр "Мэдээлэлд дурдсан асуудал нь ЭХТА-22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байх тул мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллыг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст прокурорын хяналтын харьяаллыг НПГ-т тус тус тогтоож шалгуулахаар хүргүүлсэн талаар хариу ирсэн.

				газрыг олгосон байна. Харин Эрдэнэс-Тавантолгой ХК өөрийн тусгай зөвшөөрлийн талбайн газар эзэмших эрхийг бүрэн аваагүйгээс тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа болон бусад хэлбэрээр ашиглалтын талбайгаас 4,937.8 га буюу тусгай зөвшөөрөл бүхий газрын 7.2 хувийг иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр олгожээ. Үүнд: §Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011943, MV-016883 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 3 аж, ахуй нэгж, 1 иргэнд 39.2 га газрыг эзэмших; §Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-016881, MV-016882 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 5 иргэн, 2 аж, ахуй нэгжид 17.3 га газрыг эзэмших, 54 иргэнд 4.1 га газрыг өмчлүүлж, 1 аж, ахуй нэгжид 2.1 га газрыг ашиглах; §Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011953 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 11 иргэн, 34 аж, ахуй нэгжид 1,786.9 га газрыг эзэмших, 6 иргэнд 0.3 га газрыг өмчлөх, 3 аж ахуй нэгжид 6.5 га газрыг ашиглах; §Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011954 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд давхардсан тоогоор 6 аж, ахуй нэгж, 14 иргэнд 94.4 га газрыг эзэмших, 10 иргэнд 0.8 га газар өмчлүүлж, 7 аж, ахуй нэгжид 165.8 га газар ашиглах; §Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011955 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд давхардсан тоогоор 55 аж, ахуй нэгж, 18 иргэнд 2,820.4 га газрыг эзэмших; §Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011956 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 1 аж ахуйн нэгжид 100.8 га газрыг эзэмших хэлбэрээр тус тус олгосон байна. 4. Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2019.07.30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийг байгуулахаар шийдвэрлэн, Цанхийн зүүн хэсгийн MV-011943 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлж, 300.0 сая төгрөгийг компанийн дүрмийн санд оруулсан байна. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн судалгааны үндсэн дээр Хонконгийн хөрөнгийн биржид 2020 оны эхний хагас жилд багтаан үнэт цаас гаргахаар төлөвлөн Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийг байгуулсан ч тухайн биржээс тавьдаг сүүлийн гурван жил санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан, менежментийн ямар нэгэн өөрчлөлт ороогүй байх зэрэг шаардлагыг уг компани хангаагүй байна.			

19

				Засгийн газрын 2020.04.27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсоноор Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК татан буугдсан байна. Эрдэнэс-Тавантолгой ХК Хонконгийн биржид 2020 оны эхний хагас жилд багтаан үнэт цаас гаргахаар төлөвлөн УИХ-аар 2019.03.22-ны өдөр батлсан ТБОНӨХБАУХАТХ-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн 3 дугаар зүйлийн 3.10-т "Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж заасны дагуу 2019-2020 онд нийт 40.3 тэрбум төгрөгийн 24 гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ авахаар шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс төсөл хэрэгжих хугацаанд 21.2 тэрбум төгрөгийг гэрээний дагуу шилжүүлсэн бөгөөд Эрдэнэс-Тавантолгой ХК 2021-2022 онд 12.5 тэрбум төгрөгийг барагдуулж, 8 гэрээний 6.6 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна . Засгийн газрын хуралдааны 27 дугаар тэмдэглэлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020.05.28-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг хариуцлагыг Эрдэнэс-Тавантолгой ХК-д шилжүүлэх, мөн тогтоолын 2.1-д Эрдэнэс-Тавантолгой ХК болон Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн хооронд нэгтгэх гэрээг байгуулах, 2.5-д Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн гэрээ, хэлцлээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага болон компанийн баримт бичгүүдийг Эрдэнэс-Тавантолгой ХК-д шилжүүлэхийг хоёр компанийн Гүйцэтгэх захиралд даалгасан байна. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020.05.28-ны өдрийн 27 дугаар тогтоолыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2020.06.10-ны өдрийн А/160 дугаар тушаалаар Эрдэнэс-Тавантолгой ХК болон Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-уудын хооронд "Компанийг нэгтгэх гэрээ"-г 2020.06.30-ны өдөр байгуулж, 2020.08.06-ны өдрийн ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулж, 2 компанийн хамтарсан ажлын хэсгийг байгуулан охин компаниас нийт 27.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 гэрээний тооцоог нягтлан ажлын баримт материалыг хүлээн авсан ч зөвлөхийн ажлын тайланг хүлээн авч, гэрээт ажлын			

				гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгч, зөвлөхүүдээс нэхэмжилсэн үнийн дүнг бууруулах талаар санал тавьж, хэлэлцээр хийгээгүй байна. Гадаадын хөрөнгийн биржид хувьцаа гаргах зөвлөх үйлчилгээний компаниудтай байгуулсан дээрх гэрээгээр "гэрээг дуусгавар болгох /цуцлах/ нөхцөл"-ийг судлан үзэхэд хэрэв Зөвлөх нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцалж болохоор заасан, мөн уг гэрээнүүдийг цааш үргэлжлүүлэлгүй зогсоож мөн тодорхой хэмжээгээр үйлчилгээг түр зогсоох буюу түдгэлзүүлсэн тохиолдолд зөвлөхөд мэдэгдлийг хүргүүлж Гэрээг цуцалж болно. Хэрвээ Захиалагч өөрийн эрх мэдлийн хүрээнд зохих үндэслэлийн дагуу энэхүү Гэрээг дуусгавар болгох шийдвэр гаргавал Зөвлөх нэхэмжлэх хүргүүлэх бөгөөд Захиалагч нь тухайн мэдэгдэл хүргүүлсэн өдөр хүртэлх Зөвлөхийн гүйцэтгэсэн ажлын тэнцүү хуваарилагдсан гүйцэтгэлийн дүнг төлнө гэж заасан бөгөөд хэрвээ маргаан гарвал Монголын Олон Улсын арбитраар шийдвэрлүүлэх гэрээний зохицуулалттай байна. Гэрээний заалтын дагуу гэрээний үлдэгдэл 10.0 тэрбум төгрөгийг 2021 оны төсөвт тусгасан байна. Харин хүлээж авааагүй 6 гэрээний үлдэгдэл төлбөрийг хэрхэхийг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ шийдвэрлээгүй үлдээсэн байна. Засгийн газрын шийдвэрээр гадаадын хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах ажил 9 сарын хугацаанд үргэлжилж зөвлөх үйлчилгээ, албан хаагчдын цалин, гадаад томилолт зэрэг зардалд 48.1 тэрбум төгрөгийг үргүй зарцуулснаас Засгийн газар Эрдэнэс-Тавантолгой ХК гадаад хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах зорилтоо хэрэгжүүлээгүй байхад өмнөх шийдвэрийг үгүйсгэсэн шийдвэр гаргасан нь хөрөнгийг үргүй зарцуулах үр дагаварт хүргэсэн тэдийгүй УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолын 1.6 дахь хэсэг хэрэгжээгүй байна.			

29	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Баруун-Урт сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн" аудит	Баруун-Урт сумын 8 дугаар цэцэрлэг нь бохир зайлуулах нэгдсэн сүлжээнд холбогдоогүй бөгөөд бохир соруулах үйлчилгээг иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Аудитаар цэвэр бохир усны тоолуурын зааltыг бохир соруулсан дүнтэй харьцуулж үзэхэд сар бүр дунджаар 130 тонн бохирын илүү бичилт хийж, төсвөөс 13.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрсэн. Мөн аймгийн Засаг даргын 2018 оны А/310 дугаар захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд тус цэцэрлэгийг бохир усны төвлөрсөн системд холбох ажилд 19.6 сая төгрөг шийдвэрлэсэн боловч холбоогүй байсан учир 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгах албан шаардлага өгсөн. Төрийн аудитын байгууллагаас өгсөн уг шийдвэр одоог хүртэл хэрэгжихгүй байгаа шалтгаан нь нэгдсэн бохирын системд холбохгүй байх сонирхлын зөрчилтэй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.05.17 1049	МУЕПГ-ын газрын 2023.05.22-ны өдрийн 4/4626 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн. ЭХТА-ийн 22.1, 22.8-т заасан г/х-ийн шинжтэй байж болзошгүй тул ЭХХШТХ-ийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 30.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар харьяаллын дагуу шалгуулахаар АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн.
30	Үндэсний аудитын газар	2023	"Монгол Улсын Их сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн"	1.Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо их сургуулийн гудамж 1-ийн 19 тоот хаягт орших МУИС-ийэ хичээлийн 6 дугаар байрны газрын 2006 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн кадастрын зураглалд 32 эргэлтийн цэгээр холбогдсон хэмжээ 1,545 м.кв байсан бол 2009.06.08-ны өдрийн кадастрын зураглалд 30 эргэлтийн цэгээр холбогдсон 1,329 м.кв хэмжээтэй болж 216 м.кв талбайгаар зөрүүтэй болж хасагдсан байна. Хасагдсан газрын бүртгэлтэй холбоотой нэмэлт материал гаргуулахаар нийслэлийн газрын албанд 2023.03.09-ний өдрийн албан бичгээр лавлагаа мэдээлэл хүссэн боловч одоогийн бүртгэлд байгаа өөрчлөлт ирүүлсэн. 2.Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах хаягт орших Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн 2007. 04. 27-ны өдрийн дугаар №0117560 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээнд 10.4 га буюу 104,00 м.кв газрын бүртгэл 2019.07.02-ны өдрийн дугаар №000006505 тоот төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд газрын хэмжээ 59,872 м.кв болж 44,128 м.кв талбайгаар зөрүүтэй хасагдсан байна. Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн Төв аймгийн Эрдэнэ сумын 1 дүгээр баг Харзтай суурин газарт оршин байгаа газраас 44,128 м.кв хэсэг нь хасагдсан нь гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд байж болзошгүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.05.19 1063	МУЕПГ-ын 2023.06.26-ны 4/5281 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
31	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын	1. Цөм сүргийн үржлийн нэгжид хурган хуц, шаардлагатай тоног төхөөрөмж, өвс тэжээл /Малчин, Зүүнговь сум/ бэлтгэх арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн 600 хурган хуцыг Зүүнговь сум хүлээн хүлээн авсан акт үйлдсэн боловч биетээр байхгүй, Малчин сум 600 хурган хуцыг хүлээн авсан боловч 200 толгой хорогдсон байна. Мөн	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.05.19 1064	МУЕПГ-ын 2023-05-30-ны өдрийн 4/4774 дугаартай албан бичгээр "2023-05-19-ний өдрийн 1064 дугаартай албан бичгээр тус газарт

			төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"	өвс, зарим багаж тоног төхөөрөмжийг дутуу нийлүүлсэн, чанарын шаардлага хангахгүй хурган хуц нийлүүлсэн гэх тайлбарыг Зүүнговь сумын Засаг даргаас ирүүлсэн. Санхүүжилтийн эрх нээлгэхийн тулд өвс тэжээл, багаж тоног төхөөрөмж гэснийг мал эмнэлгийн тоног төхөөрөмж, өвөлжилтийн бэлтгэл хангах бараа материал гэж нэршил өөрчилсөн байна. 2. Мөн Үхрийн үүлдэр угсааг сайжруулах ажлын хүрээнд Апекс Убсу консалтинг ХХК герефорд үйлдрийн 45 бяруун бух тус бүрийг 3,997,733.3 төгрөгөөр нийлүүлсэн нь зах зээлийн үнээс өндөр үнэтэй байж болзошгүй байна. 3. Цөм сүргийн үржлийн нэгжид өвөлжөө, хаваржааны хашаа байр барих ажлын амьдрах сууц, саравч, өвөлжөөний хашаа, өвөлжөөний хаалга, өвсний хашаа, устгалын цэг зэргийг санхүүжилт авахын тулд мод модон хэрэглэгдэхүүн болгон нэршил өөрчилсөн байна.			ирүүлсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг ЭХХШТХ-ийн 30.2, 30.7-р зүйлд заасан журмын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн талаар хариу ирсэн.
32	Үндэсний аудитын газар	2023	"Монголын төмөр зам ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Өвөр Монголын уурхайн үйлдвэрийн эд хөрөнгийн хамааралтай ХХК-ийн охин компани болох Монголиан уул уурхайн үйлдвэрийн хөрөнгийн менежмент ХХК, Монголын төмөр зам ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчид 2018 онд хамтран ажиллах ХАГ-18-115110/08 дугаар гэрээг байгуулж, "БНХАУ-ын Тяньжин хотын Бинхай шинэ дүүргийн Дунзяны гаалийн баталгаат боомт бүс дэх 10 га газрын түрээсийн төлбөрт 8,300,000.00 /найман сая гурван зуун/ ам.доллар төлж, "Тэзвэр логистикийн төв" төслийг 50 жилийн хугацаанд хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсон. Дээрх компаниуд нь хамтран ажиллах гэрээгээр Монголиан порт групп ХХК-ийг үүсгэн байгуулж, Монголиан уул уурхайн үйлдвэрийн хөрөнгийн менежмент ХХК нь урьдчилгаа 20 хувь буюу 1,660,000.00 /нэг сая зургаан зуун жаран мянган/ ам.долларын хөрөнгө оруулсан. Монголын төмөр зам ТӨХК 51 хувийг оруулсан гэсэн баримт үйлдсэн боловч нотлогдохгүй, Монголиан порт групп ХХК нь ямар үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй, Засгийн газрын тогтоол болон хувьцаа эзэмшигч компани хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. 2. Монголын төмөр зам ТӨХК өөрийн үйл ажиллагааны орлогоос Монголиан порт групп ХХК-д 160,000,000.00 /нэг зуун жаран сая/ төгрөгийн зээл олгож, шууд зардал болгож хаасан байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.05.29 1098	МУЕПГ-ын 2023.06.08-ны 4/5038 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

33	Булган аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн" аудит	1. Эмийн үлдэгдэл эмийн тайлангийн эхний үлдэгдлээс 1,439,4, эцсийн үлдэгдлээс 36,654,4 мянган төгрөгөөр, санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлант онд бүртгэлээр нэмэгдсэн эм, эмийн тайлангийн нэмэгдсэн эмээс 112,626,9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй; 2. Санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлант онд зарцуулсан эм, эмийн тайлангийн тайлант онд зарцуулсан эмээс 77,728,2 мянган төгрөгөөр зөрүүтэй; 3. Тайлант онд нийт 109,815,8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан боловч эмийн тайланд 67,957,6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн тайланд орлогод аваагүй байна. Тус эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлдэг харилцагч байгууллагууд руу шилжүүлсэн мөнгөн дүн, орлогод авсан мөнгөн дүн зөрүүтэй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.06.05 1113	МУЕПГ-ын 2023.06.15-ны 4/5266 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
34	Үндэсний аудитын газар	2023	"Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Өмгөөллийн Легал линк си би эй ХХК-тэй 2020 онд Гашуун сухайтын төслийн ЕРС гэрээний асуудал, Төслийн эрсдэлийн удирдлага, компанийн засаглал өдөр тутмын үйл ажиллагаанд 8 сарын хугацаанд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх 2.695.0 сая төгрөгийн АГГ-01/271-106 тоот нууц гэрээ, 2021 онд ТНАЛТ, холболтын төслүүдэд 1.5 жилийн хугацаанд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх 2,850.0 сая төгрөгийн АГГ-01/43/13 тоот нууц гэрээ, 2022 онд Богд хан төсөлд 4 жилийн хугацаанд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх 11.115.0 сая төгрөгийн ТТЗ-МН22/06 маш нууц гэрээ нийт 3 жилийн хугацаанд 16,660,0 сая төгрөгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг ямар нэгэн харьцуулалт хийлгүйгээр байгуулж нэг байгууллагад хэт давуу байдал олгосон байна. Эдгээр гэрээнүүдийн дагуу нийт 7,753,8 сая төгрөг төлсөн. -АГГ-01/271-106 тоот нууц гэрээний төлбөр 2020-2021 онуудад бүрэн төлсөн, -АГГ-01/43/13 тоот нууц гэрээ төлбөрөөс 2021-2022 онуудад 2,280,0 сая төгрөг төлж, жилийн эцсийн байдлаар 570.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэсэн тооцоо нийлсэн акт ирүүлснийг албан ёсоор баталгаажуулаагүй байна. -ТТЗ-МН22/06 "маш нууц" гэрээний 25 хувь буюу 2,778.8 сая төгрөг 2022 онд төлсөн. Эдгээр гэрээний нөхцөл, үнэ тогтоосон байдал зэрэг нь хууль эрх зүйн үндэслэлтэй эсэхийг санхүүгийн тайлангийн аудитын явцад нотолж чадаагүй болно. 2. Богдхан төмөр замын төслийн Багц 1 доод бүтцийн ажлыг Зам тээвэр хөгжлийн сайд, Уул уурхай хүнд	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.06.05 1114	МУЕПГ-ын 2023.06.26-ны 4/5281 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

				үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан МН/01, МН/03, МН/28 тушаалаар Зэвсэгт хүчний жанжин штаб гүйцэтгэх болж "маш нууц" гэрээ байгуулсан. Газар шорооны ажил гүйцэтгүүлэхээр 15 туслан гүйцэтгэгч компани сонгож "нууц" гэрээ байгуулснаас 10 компанийг Зэвсэгт хүчний жанжин штаб сонгож, 5 компанийг Тавантолгой төмөр зам ХХК-ийн санал болгосноор нэмж сонгосон. Зэвсэгт хүчний жанжин штабын сонгосон 10 компанийн материалыг аудитад ирүүлээгүй. Тавантолгой төмөр зам ХХК-ийн санал болгосон 5 компанийн ирүүлсэн материалтай аудитын явцад танилцахад сонгон шалгаруулалтын шаардлага хангах баримт бичиг дутуу ирүүлсэн, үйл ажиллагаа явуулдаггүй, 1-14 саяын нийт хөрөнгөтэй шаардлага хангахгүй компаниудыг сонгож тус бүр нь 3 орчим тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Мөн Тавантолгой төмөр зам ХХК, Зэвсэгт хүчний жанжин штаб, туслан гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан 3 талт "Богдхан төмөр зам төслийн доод бүтцийн барилга угсралтын ажлын санхүүжилтийн гэрээ"-ний 3 дугаар зүйлийн 3.12-т "Тавантолгой төмөр зам ХХК нь туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төслийн удирдлагын нэгжүүдийг байрлуулах, үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор төсвийн удирдлагын зардлын дүнгээс 50 хувийг урьдчилгаа, явц дүндын, эцсийн төлбөр бүрээс хувь тэнцүүлэн суутган тооцож Зэвсэгт хүчний жанжин штабын дансанд шилжүүлнэ" гэж заасан. Уг гэрээнд Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Төрийн сан дахь дансыг төлбөр хүлээн авах данс байхаар заасан. Газар шорооны ажилд зориулан 2022 оны 9 болон 10 сард нийт 10,368.9 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн. Зам тээвэр хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар шуурхай хуралдаанаас "Богдхан төмөр зам" төслийг түр зогсоох шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 62 дугаар хуралдаанаар "Богдхан төмөр зам" төслийг "Улаанбаатар төмөр зам" ХНН-ээр хэриуцуулан гүйцэтгүүлэхийг үүрэг болгосон. Үүнтэй холбоотойгоор Тавантолгой төмөр зам ХХК 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гэрээт байгууллагууддаа "түр зогсоох" мэдэгдэл хүргүүлсэн. 2023 оны 03 дугаар сард ажлын тоо хэмжээг 26 хувийн			

				гүйцэтгэлтэйгээр баталгаажуулсан бөгөөд албан ёсоор гэрээ гүйцэтгэлийн акт үйлдэж баталгаажуулаагүй байна. Гүйцэтгэлийн урьдчилсан тоо хэмжээнд үндэслэн төлбөрийн дүнг тооцоолоход нийт 12,172,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй бөгөөд 11 байгууллагад 4.910.3 сая төгрөг нэмж төлөхөөр, 5 байгууллагаас 3,106.7 сая төгрөг буцааж нэхэмжлэхээр байна. Богдхан төмөр замын төслийн энэхүү багц дээр сонгон шалгаруулалт хуулийн дагуу явагдсан болон ажлын гүйцэтгэл албан ёсоор баталгаажуулаагүй зэргээс гүйцэтгэл үнэн зөв эсэхийг бүрэн нотолж чадаагүй болно.			
35	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн" аудит	1.Сумын ИТХ-ын 2017.09.01-ний өдрийн 23 дугаар тогтоолоор сургуулийн халуун ус, бие засах газрын 252.2 м/кв, гал тогооны 292.3 м/кв, охидын дотуур байрны 528.6 м/кв, 75а байрны 1159.8 м/кв, 75 "б" байрны 1107.0 м/кв, нийт 3339.9 м/кв газрыг "Ел-арасан" ХХК-д халааалтын зориулалтаар ашиглуулахаар хууль бусаар шилжүүлсэн байна. "Ел-арасан" ХХК-ны захирал нь тус сургуулийн нярав А.Билимхан байна. Сумын ИТХ-ын 23 дугаар тогтоолоор сургуулийн эзэмшилд байгаа газрыг "Ел-арасан" ХХК-нд халааалтын зориулалтаар ашиглуулах, уг шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга А.Ахылбек, газрын даамал Б.Берденбек нарт даалгасан байна. Сумын Засаг даргаар ажиллаж байсан А.Ахылбек нь "Ел-арасан" ХХК-ны захирал нь А.Билимханы төрсөн дүү байсан. Сургуулийн эзэмшил газрыг хувийн компанид шилжүүлсэн нь Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн 10 дугаар тогтоолын 7-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн доорх газар эзэмших, ашиглах эрхийг иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр олгосныг цуцалж, тухайн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах, газар эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг 2020 онд багтаан авч хэрэгжүүлэх, цаашид төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлсэн газраас хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байх, барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай" гэсэн зааltыг зөрчиж байгаа бөгөөд зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллаагүй байна. 2.Сургуулийн 2022 оны халааалтын зардлын батлагдсан төсөв 165,753.0 мянган төгрөг боловч захирал нь эрх мэдлээ хэтрүүлж халааалтын зардалд 309,333.0 мянган	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.06.05 1115	МУЕП-ын 2023.06.12-ны 4/5122 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

				төгрөгөөр гэрээ байгуулан оны эцэст 160,163.4 мянган төгрөгийн үндэслэлгүй өр үүсгэсэн. Сумын төсөвт байгууллагууд нэгдсэн халаалтад холбогдож сургуулийн хичээлийн байранд 2014 оноос "Жанат" ХХК-тай гэрээ байгуулан халаалт авч ирсэн бөгөөд 2019 онд гэрээний хугацаа дууссан байна. Сургуулийн зүгээс шинэчлэн гэрээ байгуулаагүй тул "Жанат" ХХК 2020.08.24-ний өдөр гэрээ байгуулах санал хүргүүлэх тухай ж/37 дугаар албан бичгээр хандаж "хариу ирүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн 196 дугаар зүйлийг 2-т зааснаар гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ" гэсэн албан бичиг хүргүүлж сургуулийн хичээлийн байрыг нэгдсэн халаалтаар хангаж ирсэн байна. Энэ хугацаанд сургуулийн зүгээс "Жанат" ХХК-тай гэрээ байгуулаагүй боловч 18,729.1 м/куб халаалтын эзлэхүүнтэй хичээлийн байранд 1м/куб-ыг 1298 төгрөгөөр тооцож халаалт авч, сард 24,310.4 мянга, жилийн дүнгээр 102,735.9 мянган төгрөг төлж, оны эцэст өмнөх оны өр 42,920.0 мянган төгрөгийг нэмж тооцоход 122,511.9 мянган төгрөгийн өртэй гарчээ. Сургууль нь 4 дотуур байр болон халуун усны байрыг нэгдсэн халаалтад холболгүй "Ел-арасан" ХХК-тай гэрээ байгуулан энгийн халаалт авч ирсэн байна. "Ел-арасан" ХХК-тай 2022 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 жилийн хугацаагаар гэрээ байгуулж, 1 м/куб-ыг 1350 төгрөгөөр тооцож 14,726.05 м/куб эзлэхүүн бүхий халаалтын талбайд сарын 19,880.1 мянган төгрөгийн, жилийн 139,160.7 мянган төгрөг төлөхөөр тусгасан байна. Халаалтын гэрээг жил бүр дүгнэж, шинэчлэн хийж байх ёстой тул энэхүү гэрээг хууль бус гэж үзэх үндэслэлтэй байна. Түүнчлэн сарын 19,880.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж, 12 галчийн цалинг сургуулийн төсвөөс цалинжуулж, "Ел-арасан" ХХК-д сар бүр 11,385.1 мянган төгрөг жилийн дүнгээр 63,017.1 мянган төгрөгийг халаалтын зардалд шилжүүлсэн. Оны эхний 9297.0 мянган төгрөгийн өрийг нэмж тооцоход оны эцэст 37,651.5 мянган төгрөгийн өртэй гарсан. Сургуулийн 75а дотуур байр 2022 оны сүүлийн хагас жилд ажиллаагүй, халаалт аваагүй боловч "Ел-арасан" ХХК-нд халаалтын зардлыг гэрээний дагуу бүрэн төлсөн байна. Үүнд нийт 11,419.8 мянган төгрөгийг хууль бусаар төлсөн байна. "Ел-арасан" ХХК-ны захирал нь тус сургуулийн нярав байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй бөгөөд сургууль нь үр ашиггүй гэрээ байгуулан			

				ажилласан байна. 3. Сургуулийн үдийн хоолыг гүйцэтгүүлэхээр 2022 оны 9-12 дугаар сард "Ай-арыс" ХХК-тай хүнсний материал бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулж үдийн хоолны батлагдсан төсвийг 48,120 хүүхэд өдрөөр батлагдсан норматив 1500 төгрөгөөр тооцож 72,172.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гэтэл үдийн хоолыг сургуулийн цэвэрлэгч, туслах тогооч нарын 5-6 ажилтнаар гүйцэтгүүлж сургуулийн төсвөөс 13,035.8 мянган төгрөгийг үр ашиггүй хууль бусаар зарцуулсан байна. Үдийн хоолны гүйцэтгэгчээр гэрээ байгуулсан компани нь тус сургуулийн нярвын хамаарал бүхий хуулийн этгээд байна.			
36	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	НББ-ээр тайлант хугацаанд Бүстийн Булгын Ундарга ХХК-аас 19,399,470 төгрөгийн бараа худалдан авч 822,410 төгрөгийг касснаас, 18,577,060 төгрөгийг харилцахаас төлжээ. Харилцах данснаас төлсөн төлбөрийн 11,232,160 төгрөгийг 8 удаагийн гүйлгээгээр харилцагчийн төрийн банкан дахь дансанд шилжүүлсэн бол 7,344,900 төгрөгийг 13 удаагийн гүйлгээгээр хувь хүний дансанд шилжүүлжээ.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.06.05 1118	МУЕПГ-ын 2023.06.14-ны 4/5204 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
37	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн" аудит	Аймагт нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж аймгийн Засаг даргын 2022.01.20-ны өдрийн А/24 дүгээр захирамжаар барьцаа хөрөнгийн данснаас төсөвт тусгагдаагүй зээлийн хүүгийн дэмжлэг олгоход Хас банкны Увс салбартай гэрээ байгуулж 99.0 сая төгрөг шилжүүлснээс 59.9 сая төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлсэн, 39.1 сая төгрөгийг хүүгийн дэмжлэгт олгосон ба зээлийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, үр дүнг тооцож ажиллаагүй байсан.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.06.05 1116	МУЕПГ-ын 2023.06.26-ны 4/5281 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
38	Үндэсний аудитын газар	2023	"Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2022 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн" аудит	Аудитын явцад тусгай зориулалтын автомашинуудын ашиглалтын байдалд шалгалт хийхэд хүрээлэнгийн 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлд бэлнээр тоологдсон. 1."УАЗ-469 – 31512" маркийн 14-26 улсын дугаартай автомашин, 1996 онд ашиглалтад орсон, 1,400,000 төгрөгийн анхны үнэтэй, үлдэх өртөгүй болсон.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2023.07.18 01/1343	МУЕПГ-ын 2023.07.27-ны өдрийн 4/6614 дугаартай албан бичгээр Гэмт хэргийн талаарх мэдээллийг хүлээн авч хянаад, мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллыг АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст, прокурорын хяналтын харьяаллыг НПГ-т тус тус тогтоосон талаар хариу ирсэн.

39	Үндэсний аудитын газар	2023	"Төрийн орон сууц кордораци ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Эко яармаг хорооллын газрыг 2014 оны 04 дүгээр сараас хойш чөлөөлөх ажил эхэлсэн ч шинээр хашаа хатгаж, газрын гэрчилгээ нэмж гаргуулсан айлуудад 1,417,885,400,0 төгрөгийн үнэ бүхий 23 байр олгосон. 2. Дуусаагүй барилга дансанд 299,829,220,0 төгрөгийн амины 2 орон сууц бүртгэлтэй байсан боловч эдгээр орон сууц бусдын эзэмшил газарт баригдсан тул газар чөлөөлөх шүүхийн шийдвэр 2021 онд гарсан байна. Орон сууцыг барихдаа бусдын эзэмшил газарт барьж төрийн өмчид хохирол учруулсан, буулгахдаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2023.07.18 01/1340	МУЕПГ-ын 2023.07.27-ны 4/6613 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
40	Үндэсний аудитын газар	2023	"Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	Орон сууцны фондыг нэмж бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж 2021 онд 51 ширхэг шинэ орон сууцыг 11,504.0 сая төгрөгөөр худалдан авсан боловч Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн "Орон сууц хувьчлах тухай" 87 дугаар тогтоолоор 2022 онд 52 орон сууцыг хувьчилсан байна. Хувьчлалыг хийхдээ байгууллагад мөрддөг "Орон сууц хувьчлах журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1.1 "20 ба түүнээс дээш жил ажилласан байх" заалтыг зөрчин 12 ажилтан, 6.1.2 "Үйлдвэрийн газраас олгодог орон сууцны санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаагүй" гэсэн тодорхойлолт байхгүй 52 ажилтан, 6.1.3 "үйлдвэрээс болон төрөөс орон сууц хувьчилж аваагүй" гэсэн тодорхойлолт байхгүй 13 ажилтанд хувьчилсан байна. Эдгээр орон сууц нь 2,856.0 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй бөгөөд үнэ төлбөргүй хувьчилсан байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2023.07.20 01/1348	МУЕП-ын 2023.07.27-ны 4/6611 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
41	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд хийсэн" аудит	Аудитаар Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах, дэд бүтэц ногоон байгууламжийг сайжруулах 199,999,7 мянган төгрөгийн тендерийн ажлыг сонгон шалгаруулахдаа Дундговь-Ус ОНӨААТҮГ-аас ирүүлсэн тендерийн бичиг баримтын бүрдэл, шаардлага хангаагүй үндэслэлээр татгалзсан мэдэгдлийг хүргүүлсэн боловч 2022.08.09-ний өдөр гэрээ байгуулан хамтран ажилласан.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2023.07.20 01/1349	МУЕПГ-ын 2023.07.27-ны өдрийн 4/6612 дугаартай албан бичгээр мэдээллийг хүлээн авч хянаад, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 30.2, 30.4, 30.7 дугаар зүйлд заасан журмын дагуу шалгуулахаар АТГ-н мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн талаар хариу ирсэн.
42	Ховд аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн	1. 2021 онд Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаа МОЭНКО ХХК-тай ус ашиглуулах гэрээг байгуулахдаа Монгол-Ус төрийн өмчит үйлдвэрийн газрын 119 дугаартай усны дүгнэлтийн онцгой нөхцөлд заасан "шүүрлийн усыг тоолуурын заалтаар тооцохгүй	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор	МУЕПГ-ын 2023.09.05-ны өдрийн 4/7757 дугаартай албан бичгээр, харьяаллын дагуу шалгуулахаар Авилгатай

29

			хэрэгжилтэд хийсэн" аудит	болохыг анхаарах" гэсэн заалтыг ус ашиглах гэрээний 2.12.3-д "Худгуудын болон шүүрлээр орж ирэх усны төлбөрийг баталгаажсан тоолуур суурилуулан усны хэрэглээг тоолуурын заалтыг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сан банкны 160000944 тоот дансанд шилжүүлнэ" гэж зөрүүтэй тусгасан нь усны дүгнэлттэй нийцэхгүй 394,5 сая төгрөгийн усны төлбөрийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. 2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас гаргаж буй дүгнэлтүүд нь харилцан адилгүй, их хэмжээний зөрүүтэй байна. 3. Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаанаас ус ашиглах гэрээг дүгнэхдээ 2021-2022 онд зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээг ашиглах дүгнэлт болон гэрээнд заасан хэмжээнээс бага ус ашиглаж байгааг харгалзаагүй, 2022 оны уурхайд шүүрэлтээр орж ирэх усны хэмжээг 25828 м3 ус байхаар тогтоож, гүйцэтгэлээр шүүрэлтээр 49358 м3 усыг шавхан зайлуулсан байхад Усны тухай хуулийн 31.2, Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолын дагуу илүү ашигласан 25530 м3 усыг шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцож, усны төлбөрийн ногдуулалтыг хийгээгүй.		2023.08.23 1493	тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн тухай мэдээлэл ирүүлсэн байна.
43	Нийслэл дэх Төрийн аудитын газар	2023	"Нийслэлийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн" аудит	1.Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний нийт 14,257.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн 8 барилгын зөрчил; 2. Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө-100 ортой цомцог гэр барих ажилд 7 байршилд нэг бүрийн өртөг 647.3 сая төгрөг, нийт 4,531.1 сая төгрөгийн өртөгтэй зөрчил; 3. Нийт 19,000.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 сургууль, цэцэрлэг худалдан авах болон засварын ажлын захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн; 4. Нийслэлийн Боловсролын газраас захиарлагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны эрх шилжүүлсэн тухай А/1027, 1028, 1029, 1030, 1031 дугаар захирамжуудаар эрх шилжүүлсэн "Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоглоом нийлүүлэх 7,277.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн; 5. Нийслэлийн Нийтийн тээврийн газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус 224 ширхэг худалдан авах төсөвт өртөг 60,560.4 сая төгрөг, 2023 оны	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.08.23 1494	МУЕПГ-ын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн №4/7752 дугаартай албан бичгээр, харъяаллын дагуу шалгуулахаар Авилгатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст, прокурорын хяналтыг Нийслэлийн прокурорын газарт шилжүүлсэн тухай мэдээлэл ирүүлсэн байна.

				3 дугаар сарын байдлаар 224 автобусыг бүрэн нийлүүлсэн ч техникийн тодорхойлолтод заасан зарим үзүүлэлт хангагдаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.			
44	Үндэсний аудитын газар	2023	"Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй зээл авч зарцуулсан. Байгууллагын харилцах данс болон кассын тайланд тусгагдаагүй 183.7 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээний баримт цахим төлбөрийн баримт системд бүртгэгдсэн.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.09.19 1748	МУЕПГ-ын 2023.09.26-ны 4/8373 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн.
45	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар	2023	"Алтай хотын цогц үйлчилгээний газар УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	Удирдлагаар ажиллаж байсан Д.Дашдаваа нь өөрийн хамаарал бүхий этгээдтэй түрээсийн гэрээ байгуулж, 16,812.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгасан.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2023.04.10 754	МУЕПГ-ын 2023.04.25-ны өдрийн 4/3653 дугаартай албан бичгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлд заасны дагуу шалгуулахаар Говь-Алтай аймгийн прокурорын газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
46	Үндэсний аудитын газар	2023	"Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийсэн" аудит	1.Техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд ЗГХЭГ-ын даргын 2019 оны 44 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсгүүд нийт 109.4 тэрбум төгрөгийн худалдан авалтын зөвлөмж гаргаснаас 38.6 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хүчингүй болгож, 70.8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхийг зөвлөмж болгосны дагуу 67.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авсан байна. 2.Монголын төмөр зам ТӨХК нь төмөр бетон дэр нийлүүлэх ажилд Улаанбаатар БҮК ХК, Дорнод ган хийц ХХК, Улаанбаатар төмөр зам ХНН-ийг сонгох боломжтой талаар Дэд ажлын хэсэгт 2019 оны 7 дугаар сарын 17, 2019.09.20-ны өдрүүдэд танилцуулж, 19, 57 дугаартай зөвлөмжийг гаргуулсан байна. 3.Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төмөр замын далан, хоолой, гүүр, эрчим хүч, шилэн кабель, холбоо дохиоллын ажил гүйцэтгэх тусвийн удирдлагын зардлын 30 хувийг "теслийн үйл ажиллагаатай холбоотой удирдлага зохион байгуулалтыг хангах" нэрээр Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар, Барилга-инженерийн цэргийн удирдах газар УТҮГ-ууд 8,951.6 сая, Улаанбаатар төмөр зам ХНН 6,462.8 сая төгрөг буюу аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний үнээс 12,215.9 сая, зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гэрээний үнээс 3,198.5 сая, нийт	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2023.11.27 01/2430	МУЕПГ-ын 2023.12.12-ны 4/1142 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				15,414.4 сая төгрөгийг суутган авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна. 4.Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд 2019.10.29-ний өдөр байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-Н19/01, BI-TTGS-CONT-0001 дугаартай гэрээний ерөнхий хэлэлцээрийн Хавсралт 6-д заасан ажлын хуваариар 32 сар буюу 2022.08.01-нд бүрэн дуусгахаар байсан боловч талууд гэрээнд өөрчлөлт оруулж хугацааг удаа дараа сунгасан. 5.Бодь интернэшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019.10.15-ны өдрийн "Гүйцэтгэлийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай" 17 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гүйцэтгэлийн баталгааг өөрийн хөрөнгөөр гаргахаар шийдвэрлэжээ. 6.Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулах гэрээг Соёолон инженеринг ХХК-тай сонгон шалгаруулалтгүйгээр байгуулахдаа гэрээ байгуулах харилцааг санамж бичгээр урьдчилан баталгаажуулсан, гэрээний үнийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй зэргээс харахад Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4 -т зааснаар албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй байна. 7.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлын санхүүжилтийн гэрээний "ХАВСРАЛТ В" болох Эрдэнэс-Тавантолгой ХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан нүүрс нийлүүлэх ЭТТ-2019/784, BI-TTGS-CONT-0003 дугаартай гэрээгээр төлбөрийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оныг дуустал 5 жилд тэнцүү хэмжээгээр нүүрсээр барагдуулахаар байсныг 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт №1-ээр тухайн оны 12 дугаар сардаа багтаан 1.5 сая тонн 90.0 сая ам.долларын нүүрсийг олгох, 2024 онд нийлүүлэх нүүрсний хэмжээнээс хасах өөрчлөлт оруулж 2019 онд 1.2 сая тонн 72.0 сая ам.долларын нүүрсийг урьдчилж олгосон.			

32

47	Үндэсний аудитын газар	2023	"Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан аудит гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт өртөг нөхөгдөх болон зардлын газрын тосны хэмжээ баталгаажуулалт"	1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4 дүгээр зүйлд зөвхөн үр ашигтай нээлт хийсэн нөхцөлд гэрээлэгч өртөг зардлыг нөхөж авахаар заасан боловч Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд үр ашигтай нээлт илрүүлсэн баримт мэдээлэл байхгүй, Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй байхад 1996-2018 оны хугацаанд 1,181.9 сая ам.долларын өртөг зардлыг нөхөн авч, 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулан тооцсон байна. 2. Гэрээний талууд хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, олборлолтод хэзээ шилжсэн талаарх үндэслэлтэй тайлбар, тодруулга, нотлох баримтыг гаргаж чадахгүй байна. Тосон Уул XIX талбайд Өртөг нөхөгдөх зардлыг анх нөхөж авсан 1996 оноос тооцвол 2016 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2023 оны 4 дүгээр сард Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа бүрэн дууссан байна. Гэрээний талууд БХГ-ээр тогтоосон хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, үр ашигтай нээлтийг хэзээ бүртгүүлсэн талаарх мэдээ, тайлан, тайлбар, тодруулга нь тодорхойгүй, нотлох баримтаар хангагдахгүй байна. 3. Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь "СОКО Монгол Инк"-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн тохиролцоо нь БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасанг хэрэгжүүлж ажиллаагүй нь байгалийн хэвлийд хууль бусаар халдсан байж болзошгүй байна. 4. Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хуулиар олгогдоогүй эрх эдэлж гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээр хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй нийцэхгүй байна. 5. Мөн гэрээлэгч, Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хооронд 2004 онд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протоколоор борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь БХГ-тэй нийцээгүй, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхойгүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023.12.26 2585 дугаар албан бичиг	МУЕП-ын 2024.01.12-ны 4/572 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн.

48	Үндэсний аудитын газар	2023	"Цахим-Монгол зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн"	Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП) боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх 6.0 сая ам.долларын гэрээт ажлын гүйцэтгэлийн 2 дахь төлбөрийг Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан төслийн удирдагч "Мэдээлэл технологийн аудит"-ын үр дүн гарах хүртэл төлбөрийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналаа мэдэгдсэн байна. • Цахим эрүүл мэнд төслийн 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 13 тоот албан бичгээр нэхэмжлэлийг хангах боломжгүй тухай Эрүүл мэндийн яаманд мэдэгдсэн боловч Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан бус хэлбэрээр үүрэг өгсний дагуу /баталгаажсан уулзалтын тэмдэглэл байхгүй/ Сангийн яаманд 2 дахь төлбөр болох 1.2 сая ам.долларын санхүүжилтийг хянан баталгаажуулсан тухай 2022. 05.23-ны өдрийн 14 дүгээр албан бичгийг хүргүүлсэн байна. • Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан захирлын 2023.02.07-ны өдрийн 026/23 дугаар албан бичгээр санхүүжилтийн гэрээнд (2006 оны 5 дугаар сард батлагдсан "Дэлхийн банкны Төслийн зарцуулалтын журам"-ын 7.1-ийн заалт) заасны дагуу нийт 1.7 сая ам.долларыг 2023.03.31-ний өдөрт багтаан Дэлхийн банканд буцаан олгох тухай мэдэгдлийг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн байна. Дүрс архивлан хадгалах (PACS) системийн патент, ашиглалтын загвар, худалдааны тэмдэг, загвар, зохиогчийн эрх, ноу-хау, эсхүл бусад оюуны өмчийн эрхийн өмчлөлийг гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулаагүйгээс эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэгч "Амин" ХХК-д төлбөр төлж нэвтрүүлэхээр байна. Системийг боловсруулан хэрэгжүүлэх 1.9 сая ам.долларын MN-MOH-120874-NC-RFB-PACS /№ 150/ дугаар гэрээг "Арема жапан" ХХК, "Амин" ХХК-ийн түншлэлтэй байгуулсан гэрээний лицензтехникийн мэдээллийг ашиглах талаар 15 дугаар зүйлийн 15.1-д "...нийлүүлэгчийн эсвэл аливаа гуравдагч талын патент, ашиглалтын загвар, худалдааны тэмдэг, загвар, зохиогчийн эрх, ноу-хау эсвэл бусад оюуны өмчийн эрхийн өмчлөлийг захиалагчид шилжүүлнэ гэсэн ойлголт биш юм." гэж тусгасан нь хэрэглэгчийн систем ашиглах, хөгжүүлэх, сайжруулах ажиллагаанд саад болсон байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023.12.26 01/2582 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.01.12-ны 4/571 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
49	Үндэсний аудитын газар	2023	"Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл"	"Борнуур хөдөлмөр амралт"-ын зусланг Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2001 оны 61 дүгээр тогтоолоор "Нийслэлийн 51 дүгээр дунд сургуулийн хөдөлмөр амралтын зуслангийн барилга"-ыг 2001 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад оруулан, дуудлага худалдаагаар	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг	МУЕПГ-ын 2024.01.12-ны 4/575 дугаар албан бичгээр харьяаллын дагуу АТГ-т шалгуулахаар

				худалдаж, хувьчлахаар шийдвэрийг гаргасан боловч холбогдох баримт материал байхгүй. -"Нарлаг" хүүхдийн зусланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 66 дугаар "Жагсаалт батлах" тухай тогтоолоор "2003 онд удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх нийслэлийн өмчит хүүхдийн зуслангуудын жагсаалтыг баталж, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008 оны 92 дугаар тогтоолоор өмчлөх эрхийг шилжүүлсэн. Гэвч Холбогдох байгууллагуудаас 2004-2008 оны хугацаанд "Нарлаг" хүүхдийн зусланг хувьчилсан дээрх шийдвэрүүдтэй холбоотой архивын баримт материал байхгүй. -"Соёл" хүүхдийн зусланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 66 дугаар "Жагсаалт батлах" тогтоолоор "2003 онд удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх нийслэлийн өмчит хүүхдийн зуслангуудын жагсаалтыг баталж, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 31 дугаар тогтоолоор хувьчилсан боловч хувьчлагдсанаас хойш буюу 2007 оноос хойш үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй, аудитын баг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зуслангийн талбарт ажиллахад барилга, байгууламжийг буулгасан байдалтай байсан ба байшингийн суурь үлдсэн, архивд баримт, материал байхгүй. -"Өлзийт" хүүхдийн зусланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 66 дугаар "Жагсаалт батлах" тогтоолоор "2003 онд удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх нийслэлийн өмчит хүүхдийн зуслангуудын жагсаалтыг баталж, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 33 дугаар тогтоолоор хувьчилсан. Гэвч хувьчлагдсанаасаа хойш бизнес төлөвлөгөөний дагуу ажиллаагүй буюу үйл ажиллагаа явуулаагүй, гуравласан гэрээг зөрчсөн. Аудитаар талбар дээр очиж ажиллахад үйл ажиллагаа зогссон, байшин барилгууд нурж эвдэрсэн, үйл ажиллагаа явуулах боломжгүй нурсан, ашиглах боломжгүй болсон. Дархан-Уул аймгийн "Монгол хүүхдийн хуучин пионер"-ын зусланг Дархан хотын ардын хурлын гүйцэтгэх захиргааны өмч хувьчлалын комиссын 1992 оны 58 дугаар тогтоолоор 28 байшинг 21 иргэнд 992 ширхэг тасалбараар хувьчилжээ. Зуслангийн эд хөрөнгийг хувьчлахдаа хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, дуудлага		түр орлон гүйцэтгэгч 2023.12.26 01/2616 дугаар албан бичиг	шилжүүлсэн талаар хариу ирсэн.

				худалдаа зохион байгуулаагүй, шинэ өмчлөгчийг нотолсон гэрчилгээ олгоогүй байна.			
50	Үндэсний аудитын газар	2024	"Төрөөс шинжлэх ухаан технологийн салбарын талаар баримтлах бүй бодлогын хэрэгжилт үр нөлөө" сэдэвт	Шинжлэх ухаан технологийн сангийн хэлтсийн даргаар 2011-2017 онд ажиллаж байсан Б.Ганцэцэг албан үүргээсээ чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн дотор буюу 2017 оны 5 дугаар сараас эхэлсэн тус сангаас санхүүжүүлэх "судалгаа боловсруулан ажлын үр дүнг хамгаалах ашиглах эрх зүйн орчин тогтолцоог боловсронгуй болгох оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлэх арга зам сэдэвт 40,000,000.0 төгрөгийн төсөл хэрэгжүүлэх гэрээг Боловсрол соёл шинжлэх ухааны яам Шинжлэх ухаан технологийн сантай байгуулсан.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Тамгын дарга, тэргүүлэх аудитор 2024.02.01 02/179 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.02.13-ны өдрийн 4/1368 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хэрэг үүсгэн шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
51	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Байгаль орчин уул, уурхайн нөхөн сэргэлтийн үр дүн" аудит	Улаан загалмайн хороотой байгуулсан гэрээний хүрээнд тус байгууллагын Хаан банкны 5630003644 тоот дансанд аймгийн төрийн сангаас 2023.05.10-ны өдөр 250.0 сая төгрөгийг шилжүүлжээ. Мөн гүйлгээний санхүүгийн баримтыг тулгалт хийхэд ууттай чихэр, дотоодын үйлдвэрийн гурилан боов, хуурай сүү, цай, витагрип зэрэг бүтээгдэхүүн худалдан авч 4000 ширхэг бэлгийн багц бэлтгэж уулзалт, хурал цуглаан дээр Улаан загалмайн хүмүүнлэгийн тусламж нэрээр иргэдэд тараасан байна. Бест колор интернэшнл ХХК-д шилжүүлсэн 19.9 сая төгрөгийн хэвлэмэл материалыг эх бэлтгэж өгөөгүй гэх шалтгаанаар одоог хүртэл хэвлүүлээгүй, компани нягтлан бодох бүртгэлд урьдчилж олсон орлого дансанд бүртгэлтэй байна. Улаан загалмайн хороотой байгуулсан гэрээний 2 дугаар зүйлийн 2.1-д заасан чиг үүргийг Засаг даргын мэрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1,090.0 сая, гамшгаас хамгаалах эрсдэлийн санд баталсан 710.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэх бүрэн боломжтой байхад тусгайлан төсөв баталж зарцуулсан.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.02.29 426 дугаар албан бичиг	Нийслэлийн Прокурорын газрын 2024.03.19-ний өдрийн 4/2380 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хэрэг үүсгэн шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.
52	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" аудит	1."Хөрөнгө оруулалт-хөгжлийн чуулган-2023" арга хэмжээг зохион байгуулахтай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2023.04.19-ний өдрийн А/232 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулсан байна. Арга хэмжээнд шаардлагатай төсвийг ИТХ-аар тусгайлан батлуулаагүй, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй байгуулсан нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах 2023 оны гэрээнд тусган бүрдүүлсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээнд зочид төлөөлөгчдийн хүлээн авалт, чуулганы үйл ажиллагааг шууд дамжуулах зардал багтсан байна. Гэтэл уг чуулган зохион байгуулахтай холбоотойгоор "Цайрт Минерал" ХХК-аас шууд дамжуулалтын зардал 60.0 сая төгрөгийг Датуком (BB8 орон нутгийн телевиз) ХХК, зочид төлөөлөгчдийг хүлээн	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.02.29 425 дугаар албан бичиг	Нийслэлийн Прокурорын газрын 2024.03.21-ний өдрийн 1/1738 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хэрэг үүсгэн шалгуулахаар шилжүүлсэн талаар хариу ирсэн.

36

				авах зардалд 54.6 сая төгрөгийг Дарьганга катеринг ХХК-ийн дансанд шилжүүлсэн нь Нүүдэлчдийн агуулга НҮТББ-ын гэрээний хавсралтад заасан үйл ажиллагааны зардлуудтай давхардаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа "TV9" телевизтэй холбогдож шууд дамжуулалтын зардлын тооцоог гаргахад орон нутагт дунджаар 10.0-15.0 сая төгрөгийн тарифтай үйлчилгээ үзүүлдэг байна. Датуком ХХК-ны дансны хуулгыг авч тулган баталгаажуулалт хийхэд уг шилжүүлсэн мөнгөн дүнгийн 10 хувь болох 6.0 сая төгрөгийг тус байгууллагын дансанд үлдээж, үлдсэн 54.0 сая төгрөгийг бэлнээр гаргасан байна. 2. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудтай жил бүр аймаг, сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний үүрэгт сум, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг авахаар тусгасан байдаг. Олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Алаг тогоо ХХК нь 2022 оны гэрээнд тусгагдсан санхүүгийн дэмжлэгийг төвлөрүүлээгүй байна. Тус компанийн удирдлагаас гэрээний төлбөр төлөөгүй шалтгааныг тодруулахад 2023.10.13-ны өдрийн 23/104 албан бичгээр хамтран ажиллах гэрээний хүрээнд 120.0 сая төгрөгийг Тэнгэр трэвел ХХК-ийн дансанд сургалт, аяллын зардал гэсэн гүйлгээний утгатайгаар шилжүүлсэн талаар тайлбар ирүүлсэн. Тэнгэр тревэл ХХК-д хүсэлт гаргаж, аялалд хамрагдсан албан хаагчдын жагсаалтыг авч үзэхэд аймгийн ИТХ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтэн, хууль хүчний байгууллагын дарга зэрэг нийт 29 хүн хамрагджээ. Энэ нь төсвийн орлогыг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй төсвөөс гадуур зарцуулж, холбогдох албан тушаалтнуудыг аялуулсан, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байна.			
53	Үндэсний аудитын газар	2024	"Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2022.04.18-ны өдөр ЭТТХК-20221685 дугаартай уурхайн үйл ажиллагаанд шаардагдах уулын үндсэн болон туслах нийлүүлэгчийг сонгох 14 багц 120 ширхэг техник худалдан авах 1,266,556.4 сая төгрөгийн төсөвтэй тендер шалгаруулалтыг зарласан байна. 2. Тавантолгой түлш ХХК-д хамаарах асуудлын талаар: Эрдэнэс-Тавантолгой ХК нь Тавантолгой түлш ХХК-д	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.03	МУЕПГ-ын 2024.04.24 1/3831 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

37

				эргэн төлөгдөх нөхцөлтэй 15 гэрээг байгуулж, гэрээний үүргийн дагуу 1,067,531.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гэрээг хэрэгжүүлэгч Тавантолгой түлш ХХК-д гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, зарим төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байна. Тавантолгой түлш ХХК нь Эрдэнэс-Тавантолгой ХК-тай байгуулсан ЭТТ-2022/83, ЭТТ-2022/502, ЭТТ-2022/518 дугаар гэрээний дагуу авсан эргэн төлөгдөх, урт хугацаатай хөрөнгийг Барилгын тухай хууль, барилгын норм дүрэмд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд, зарим мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах шийдвэр гарган албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж улсад их хэмжээний хохирол үүсгэсэн байж болзошгүй байна. 3. Ашигт малтмалын тухай хуульд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ) нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг холбогдох хууль, дүрэм журам судалгааны арга, аргачлалтай нийцэж буй эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх чиг үүрэгтэй байна. 4. Эрдэнэс-Тавантолгой ХК болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн хооронд 2022.06.28-ны өдөр Богдхан төмөр зам төслийн суурь бүтцийн барилга угсралтын бүтээн байгуулалтын ажлын МН-ЭТТ-2022/497 дугаартай 670.2 сая ам.долларын үнийн дүн бүхий санхүүжилтийн гэрээг байгуулж, 6.2-т заасныг зөрчин, өнөөдрийг хүртэл ажлын гүйцэтгэл баталгаажаагүй байна. Тус төсөлд санхүүжүүлсэн хөрөнгийг гэрээний 7.1-т заасныг зөрчиж зориулалтын бусаар зарцуулж Өмгөөллийн ЛЕГАЛ ЛИНК СИ БИ ЭЙ ХКК-тай 2022 оны 8 дугаар сарын 30-ний өдрийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай ТТЗ-МН22/06 дугаартай 11,115.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулж, 2022.09.02-ны өдөр 2,778.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна. 5. Тавантолгой ХК нь Бахархалт тээвэрчид ХХК-тай 2022 онд "20,000 тонн нүүрс худалдах, худалдан авах" гэрээ байгуулж, урьдчилгаа болон төлбөр төлөөгүй байхад 19,997.8 тонн нүүрс нийлүүлж, 6,969.5 сая төгрөгийн авлага үүссэн төлбөрийг гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс 3,484.7 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.		907 дугаар албан бичиг	

54	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Дундговь ОНӨААТҮГ 2023 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1."Дундговь-Ус" ОНӨААТҮГ-ын хөрөнгөөр хийгдэх хатуу түлш/нүүрс нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж, нүүрс худалдан авахдаа тендерийн баримт бичгээ заасан үнийг өөрчилж гэрээ байгуулсан; 2. Тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс нүүрс худалдан авсан, Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Биг могул коул энд энержи" ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд хандивласан нүүрсийг бүртгэлд орлогоор хүлээн аваагүй зэрэг нь хувь хүнээс хий худалдан авалт хийж, мөнгө дамжуулан гаргасан байх эрсдэлтэй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.05 914 дугаар албан бичиг	МУЕПГ-аас хариу ирээгүй
55	Булган аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн 2023 санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Тайлант онд өөрийн хөрөнгөөр 13.9 сая төгрөгийн үнэтэй 04кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг "ЭБЦТС" ТӨХК-тай 2 талт гэрээг тамга тэмдэгээр баталгаажуулаагүй, гэрээ байгуулаагүй "Кибержаал" ХХК-ны дансанд мөнгийг шилжүүлсэн байна. 2. "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-д хүлээлгэж өгснийг тулган баталгаажуулахад 10,493 боодол өвс, 54 тн тэжээлийг худалдан борлуулж үлдэгдэл 27.0 сая төгрөгийн 4,507 боодол өвс, 14.4 сая төгрөгийн 16 тн тэжээлийг дутуу нийлүүлсэн байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.05 915 дугаар албан бичиг	МУЕПГ-аас хариу ирээгүй
56	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. Аудитаар аймгийн Эрүүл мэндийн газар нь Хяргас, Ховд сумдын Эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор 147,800,000 төгрөгийн 2 түргэн тусламжийн авто машины худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль зөрчиж шууд худалдан авалт хийсэн байна. 2. "Нээлттэй Увс аймаг" хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 29,000.0 мянган төгрөгийн хандивыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авч зарцуулсан байна. Мөн хандив өгсөн "Гэрэлт шугам ХХК", "Барилгын инженерүүд ХХК", "Ундарга петролиум ХХК", "Сантех Увс ХХК", "Түгээмэл цамхаг констракшн ХХК", "Дэглий цагаан ХХК", "Бошигтын хишиг ХХК", "Цэнгийн зам ХХК"-ыг 2023 онд тендерт шалгаруулж ажил гүйцэтгүүлсэн нь ашиг сонирхол үүссэн байж болзошгүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.16 1011 дугаар албан бичиг	МУЕП-ын 2024.04.24 1/3830 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
57	Үндэсний аудитын газар	2024	"Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын эзэмшлийн газар дээр 600 айлын "Уурхайчин-2 орон сууц"-ыг Өргөө Хаан Констракшн ХХК нь 100 хувь өөрийн хөрөнгөөр барьж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдад 1м2-ыг 1.5 сая төгрөгөөр худалдан борлуулах нөхцөлтэйгөөр 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "Ажилтнуудыг орон сууцжуулах барилгын ажил"-ын гэрээг байгуулсан байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	МУЕПГ-ын 2024.05.01-ний 1/4052 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				Тус гүйцэтгэгч компани нь орон сууцыг барих явцад гэрээнд заасан 1м2-ын үнийг нэмэгдүүлэх санал тавьсныг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ хүлээн зөвшөөрөөгүйгээс гүйцэтгэгч компани 2021 оноос барилгын ажлыг бүрэн зогсоосон байна. Урьдчилгаа төлсөн ажилчид Өргөө Хаан Констракшн ХХК-д гомдол гаргасан бөгөөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Эрдэнэс монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 31 дүгээр тогтоол, хурлын тэмдэглэл, Ерөнхий захирлын 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/625 дугаар тушаалыг үндэслэн байрны урьдчилгаа төлбөр 8,292.2 сая төгрөг, менгений цаг хугацааны алдагдсан боломжийн өртөгт 1,474.1 сая төгрөгийг нэмж тооцон, нийт 9,739.0 сая төгрөгийг 330 ажилчдад олгосон байна. Өргөө хаан констракшн ХХК-ийн өмнөөс ажилчдын төлсөн байрны урьдчилгаа барагдуулан авлагаар бүртгэсэн боловч, тус компани нь хүлээн зөвшөөрч тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. 2.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байхдаа ажиллагсдыг орон сууцжуулах бодлогын хүрээнд Москва-300, Эко-400, Залуус-1000 орон сууц төсөлд шаардагдах барилгын материал, хайрга, дайрга, бетоны хэрэгцээг хямд өртөөр, стандарт, норм, норматив, чанарт нийцүүлэн хангах зорилгоор өөрийн эзэмшлийн тусгай зөвшөөрөлтэй талбайг 2 компанид гэрээгээр ашиглуулж байна. MV-002606 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 95.7 га бүхий түгээмэл тархацтай "Дэлт толгой" ордыг Дэлт хошуу ХХК-д 10 жилийн хугацаатай ашиглуулахаар 2015 оны 7 дугаар сарын 16-ны өдөр, MV-020733 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1,529.31 га талбайд орших "Бага залуу овоо" нэртэй ордын 33 га талбайг Булган базальт ХХК-д 5 жилийн хугацаатай ашиглуулахаар 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр тус тус гэрээ байгуулсан байна.		2024.04.22 1036 дугаар албан бичиг	
58	Үндэсний аудитын газар	2024	"Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2021-2023 оны үйл ажиллагааны үр дүн" аудит	Улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд нийгэмд шүүмжлэл дагуулсан "Ногоон автобус"-ыг нийлүүлсэн "Тэнүүн Огоо" ХХК нь "Амжилтын гүүр" 30 минутын захиалгат хөрөг нэвтрүүлгийг МҮОНРТ-ээр гэрээ байгуулалгүй, төлбөрийг явуулын станц хэлбэрээр тохижуулсан автобус нийлүүлэх солилцооны үндсэн дээр барагдуулахаар хэлэлцэн тохирсны дагуу Монголын үндэсний телевизээр 2022 оны 9 дүгээр сарын 25, 10 дугаар сарын 06-ны өдрүүдийн эфирийн оргил цагаар нэвтрүүлсэн байна. Мөн тус компанитай холбоотой мэдээ, сурвалжлагыг бэлтгэн Монголын мэдээ сувгаар	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.23 1043 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.01 1/4054 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

40

				удаа дараа олон нийтэд түгээсэн байна. Гэвч МҮОНРТ нь уг автобусыг 2023 онд нэг удаагийн арга хэмжээнд авч ашигласан байх бөгөөд аудитаар биет горим сорил хэрэгжүүлэхэд уг хөрөнгө бодитоор оршин байхгүй, холбогдох ажилтнуудаас тайлбар, тодруулга авахад тус компани нь автобусыг буцаан авсан гэж тайлбарласан. "Тэнүүн Огоо" ХХК нь хэлэлцэн тохирсны дагуу телевизийн захиалгат нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсөө МҮОНРТ-д одоог хүртэл төлөөгүй байна.			
59	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланд хийсэн" аудит	Аудитаар "Нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж аймгийн Засаг даргын 2022.01.20-ны өдрийн А/24 дүгээр захирамжаар барьцаа хөрөнгийн данснаас зээлийн хүүгийн дэмжлэг гэж Хас банкны Увс салбартай гэрээ байгуулан 99.0 сая төгрөг шилжүүлснээс 59.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, 39.1 сая төгрөгийг хүүгийн дэмжлэгт олгосон" зөрчилд 2023.04.20-ны өдөр 01/20/H2060410, УВА-2023/НА/СТА/ТЕЗ дугаар бүхий "Төлберийн акт" тогтоосон. Гэтэл 2023 онд аймгийн нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөр, хүнсний нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардлаас Хаан банкны Увс салбартай тендер, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр аймгийн Засаг даргын 2023.02.01-ний өдрийн А/47 дугаар захирамжаар 200.0 сая төгрөгийг, 2023.12. 22-ны өдрийн А/798 дугаар захирамжаар 186.6 сая төгрөгийг банкнаас олгох зээлийн хүүгийн төлбөрийн зарим хэсгийг төлөхөд олгож, зөрчлийг давтан гаргасаар байгаа нөхцөл байдал нь нийтийн албан тушаалтан өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон байж болзошгүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.29-ний өдрийн 1178	МУЕПГ-ын 2024.05.08 1/4310 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
60	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" аудит	1."Даланзадгад-Баяндалай-Ноён-Сэврэй-Гурвантэс" чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих 23,667.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн өгөгдлийн шалгуур үзүүлэлтэд тусгасан түншлэлийг төлөөлөгч эрх бүхий гишүүний борлуулалтын орлого 40 ба түүнээс дээш хувьд хүрэхгүй байхад гүйцэтгэгч компани болох "Хүлгийн дээд" ХХК-ийг шалгаруулсан; 2. Даланзадгад суманд худалдааны төв захын барилга барих 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа мөн борлуулалтын орлогын шаардлага хангаагүй гүйцэтгэгч компани болох "Эрчим өргөө" ХХК-ийг шалгаруулсан; 3. Даланзадгад суманд мэдээллийн технологийн төв, сургалт, дундын оффисын "DATA" төв байгуулах" 1,991.6	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.05.08 1191 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.08 1/4308 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын тендер шалгаруулалтын бичиг баримтыг хуульд нийцүүлэн боловсруулаагүйгээс тендерийн шаардлага хангаагүй гүйцэтгэгч компани болох "Этүгэн жим" ХХК-ийг шалгаруулсан байна.			
61	Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Эрдэнэмандал сумын "Ар саравч" ОНӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	1. "Ар саравч" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг Эрдэнэмандал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 дугаар тогтоолоор мах боловсруулах үйл ажиллагаа явуулах чиглэлээр байгуулсан боловч тус газар нь тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байна. Тус газар нь "Мал нядалгааны газар болон мах боловсруулах үйлдвэр байгуулах тухай" төсөл хэрэгжүүлэхээр 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 66,000,0 мянган төгрөгийн зээл авч, уг зээлээс 6,000.0 мянган төгрөгийг тус газрын захирлын дансанд, 60,000.0 мянган төгрөгийг хувь хүмүүсийн дансанд шилжүүлэн зарцуулсан байна. 2. Мөн тус газар нь 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд 66,000,0 мянган төгрөгийг мал амьтад, байгууллагад төлөх өглөг дансанд үлдэгдлээр тайлагнасан байна. Аудитын явцад шалгагдагч байгууллагаас ирүүлсэн тайлбарт "...хашаа, гадна тохижилт, ажилчдын амрах байр барьж, тоног төхөөрөмж худалдан авсан" гэх боловч хөрөнгийн зарцуулалт нь "мал бэлтгэл" гэсэн гүйлгээний утгаас зөрүүтэй байх бөгөөд санхүүгийн тайлагналыг анхан шатны баримтад үндэслээгүй, зөрүүтэй тайлагнасан, санхүүгийн тайлагналын хангалттай бөгөөд зохистой байх зарчмыг хангаагүй байна. 3. Түүнчлэн сумын Хоршоо хөгжүүлэх сангаас "Ар саравч" ОНӨААТҮГ-т олгосон зээл нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг зөрчсөн байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.29-ны өдрийн 1179 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.08 1/4309 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
62	Үндэсний аудитын газар	2024	"Галт тэрэг хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн" аудит	"Ди Вай Кэй Би" ХХК-тай байгуулсан №217, №125 дугаартай Хатуу хучилттай авто замыг гүйцэтгэх ажлын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 2023 оны Худалдан авалтын төлөвлөгөөнд батлагдаагүй Шүүлтүүртэй бутлуурын завод 230,000.0 ам.доллар буюу 790,450,200.0 төгрөг, Асфальт дэвсэгч 245,350.0 ам.доллар буюу 843,204,159.0 төгрөг, Асфальтын завод 340,000.0 ам.доллар буюу 1,168,491,600 төгрөгийн хөрөнгийг огт тендер зарлалгүй шууд худалдан авах гэрээг байгуулж, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хөрөнгө хүлээн	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.04.22 1037 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.01 1/4053 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				авсан актаар баталгаажуулсан баримт үйлдсэн байна. Аудитын явцад эдгээр хөрөнгийг бодитоор хүлээлгэн өгсөн эсэхийг тулгахад асфальтын болон бутлуурын завод биетээр нийлүүлэгдээгүй байна.			
63	Завхан аймаг дахь ТАГ	2024	"Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх" аудит	Завхан аймгийн Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын дансанд бүртгэлтэй 49-48 УНЛ улсын дугаартай Land cruiser-105 маркийн автомашин болон автомашины бичиг баримт байхгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ыг тус тус зөрчсөн байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.05.09 1260 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.14 1/4588 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
64	Нийслэл дэх Төрийн аудитын газар	2024	"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн" аудит	УБЗАА-наас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 2 ТАХ-ний хүрээнд нийлүүлэгдсэн тээврийн хэрэгслүүд нь ашиглагч байгууллагын өмчлөлд шилжин ирснээс хойш нийт 332.12 сая төгрөгийг засвар үйлчилгээнд зарцуулсан бөгөөд үүний 134.0 сая төгрөгийг бараа, ажил үйлчилгээг хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх 1 жилийн хугацаанд эвдрэл гэмтэл гарч засварт хөрөнгө зарцуулсан байхад ашиглагчаас тодруулалгүйгээр барьцаа хөрөнгийг чөлөөлсөн. Өнөөдрийн байдлаар нийлүүлэгдсэн автомашинаас 1,560.46 сая төгрөгийн үнийн дүнтэй хог тээврийн 13 авто машин бүрэн эвдэрч зогссон. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжсэн шинээр хэрэгжүүлэх "Нийтийн тээврийн автопарк"-ын барилга барих ТАХ-ний ХАА-г зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүд нь холбогдох зөвлөмжийг мөрдөөгүй, ТББ-т тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжсэн шинээр хэрэгжүүлэх "Нийтийн тээврийн автопарк"-ын барилга барих ТАХ-ний барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг өгсөн албан тушаалтан тодорхойгүй, баримтаар нотлогдохгүй байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.05.14 1261 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.14 1/4591 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.
65	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" аудит	1. Барилга угсралтын ажлын тендерт Жи Жи Ай ХХК болон Хүннүгийн говь ХХК-ний түншлэлээр ажлыг хамтран гүйцэтгэхээр компаниудын дүрэмд болон эдийн засгийн сонирхолд нийцсэн аж ахуйн нийтлэг зорилтыг хангахын тулд хамтарсан үйл ажиллагаа явуулах, хамтран ажиллах гэрээ байгуулан оролцож түншлэлийн нийлбэр үзүүлэлтээр тендерийн үндсэн шалгуур хангаж шалгарсан боловч барилга угсралтын ажлын гэрээ байгуулахдаа зөвхөн нэг компанитай үндсэн гэрээ болон нэмэлт гэрээ байгуулсан;	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2024.05.09 1257 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.05.14 1/4590 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				2. Барилга угсралтын ажлын явцад барилгын өрөө тасалгааны төлөвлөлт зохион байгуулалт, гадна фасадын хийцэл, гадна ханын дулаалгын материалыг бүрэн өөрчилсөн бөгөөд үүнээс хамааралтайгаар хорших хэсгүүдийн зураг төслийн өөрчлөлтийг хийлгэж дахин магадлалаар оруулаагүй; 3. Театрын барилгын гадна архитектурын хийцэл болох металл татанг зураг төсөвгүй гүйцэтгэсэн; 4. Батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй ажилд Жи Жи Ай ХХК-д 3,130.1 сая төгрөг, Энхбодиз ХХК-д 290.3 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон; 5.Аймгийн Засаг даргын захирамжаар томилсон барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссыг 25 гишүүнээс 4 гишүүн оролцоогүй 84%-ийн ирцтэй зохион байгуулж, комиссын бүрэлдэхүүнд ажилласан нэр бүхий 3 гишүүн татгалзсан байхад барилгыг байнгын ашиглалтад авсан; 6. Барилга нь галын аюулгүй байдлын болон эрүүл ахуйн шаардлага хангахгүй талаар мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээр нотлогдсон; 7. Хөгжимт жүжгийн театрын барилга нь батлагдсан зураг төсвөөс зөрүүтэй; 8. Барилга нь төлөвлөлтийн үндсэн хүчин чадалд хүрэхгүй буюу 850 хүний суудалтай байхаас 702 хүний суудалтай байгаа нь ашиг сонирхол үүссэн байж болзошгүй байна.			
66	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	2024	"Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" аудит	Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилгын ажлыг бараа материал худалдан авахаар төсөвт тусгаж, тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тендер зохион байгуулсан дараах зөрчлүүд илэрсэн. 1. Дорнод аймгийн Засаг дарга болон "Өршөөлтийн ариун ХХК"-ийн хооронд 2023 оны 03 дугаар сарын 30-ний өдөр "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-ын нэгдсэн авто гражийн материал худалдан авах ДОАОНӨГ/202312001/ОНТ-1.1.7 дугаар ажлын гэрээ; 2. Улаанбаатар хот дахь хангамжийн төлөөлөгч Б.Отгонбатын 2023.01.25-ны дараа тооцооны зардлын баримтад Дорнод аймгийн "Топ материал" ХХК-иас 2,171,400.00 төгрөгийн материал авсан гэж тайлагнасан байна. Мөн энэ материалын тээвэрт 490,000.00 төгрөгийг зарцуулсанаар тайлагнасан. 3. 2023.11.07-нд Хаан банкаар Т.Батдоржид тээврийн зардал 600,030.00 төгрөг олгосон. Материал нь "Дорнын наран зүг" ХХК-ийн нийлүүлсэн 13,440,000.00 төгрөгийн лист төмөр, трубаны тээврийн зардал байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	Монгол Улсын Ерөнхий аудитор 2024.06.24 1546 дугаар албан бичиг	МУЕПГ-ын 2024.07.04 1/5525 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

				4. 2023.12.14-нд Хаан банкаар Н.Цэнсүрэнд УБ-Дорнод хооронд "Дорнын наран зүг" ХХК-ийн 25 тн тулгуурыг тээвэрлэсэн тээврийн хөлс олгосон байна. ХА/2023/40 гэрээ 6114-00-1700 тээврийн зардал дансанд бүртгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (2005 оны) хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1-т заасныг зөрчиж, агуулгыг өөрчлөх бус төсөвт өртгийг нэмэгдүүлэн тендер зарласан байна. 5. 2023.06.30-нд Хаан банкаар Д.Түмэндалайд УБ-Дорнод хооронд "Дорнын наран зүг" ХХК-ийн чулуутай хар цаас 7 тн-ын ачааны тээврийн хөлс олгосон байна. 6. Чойбалсан дэд станц 6кв талаас ТЭЦ ЯЧ №23-ын хооронд ЦДАШ /цахилгаан дулаан агаарын шугам/ барих ажлын тендерт тус ажлын төсвийг хийж, хянасан Цахилгаан шугам сүлжээ цехийн дарга Ж.Баярын төрсөн дүүгийн компани болох "Хишигтпартнерс" ХХК шалгарсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (2005 оны) хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Дараах нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ", 14.1.5-д "тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой" гэж заасныг тус тус зөрчсөн байна.			
67	Үндэсний аудитын газар	2024	"Туул голын сав газрын захиргаа санхүүгийн 2023 оны аудитын тайланд хийсэн" аудит	2019 онд "Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх" төслийг хэрэгжүүлэхэд 800.0 сая төгрөгийн төсвийг дээд шатны төсөв захирагчаас Туул голын сав газрын захиргаанд эрх шилжүүлж "Ховд Тул ХХК"-тай шууд гэрээ байгуулж, гэрээний дагуу 548.8 сая төгрөгийг шилжүүлсэн боловч дээрх ажлыг хүлээлцээгүй, гэрээний дагуу ажил хийгдээгүй, хөндлөнгийн үнэлгээгээр зарцуулсан төсөвт өртөгт тохирсон ажил хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас он дамнасан урьдчилгаа үүссэн байна.	Монгол Улсын Ерөнхий Прокурор	2024.05.02 1204 дугаартай албан бичгээр	МУЕПГ-ын 2024.05.14 1/4589 дугаар албан бичгээр харьяаллын дагуу шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай хариу ирсэн.

---o0o---